ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН
ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ /2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС/

2025 оны 12 дугаар сарын 09 Номгон

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Төсөв /Эх үүсвэр/ | Үр дүнгийн үзүүлэлт | | Хүрсэн түвшин |
|---|---|---|---|---|---|
| | | | Шалгуур үзүүлэлт | Хүрэх түвшин | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| Нийтлэг эрх үүрэг | | | | | |
| 1 | Гэр бүл хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд нь Баянхонгор аймагт хууль болон үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, зохион байгуулахад зориулж 10.459.980.2 мянган төгрөгийн санхүүжилт олгоно | 10.459.980.2 | Гүйцэтгэлийн хувь | 100 | Улсын төсвөөс олгох санхүүжилтийг бүрэн олгосон<br>**Хэрэгжилтийн хувь 100** |
| 2 | Засаг дарга нь орон нутгийн хөдөлмөр эрхлэлт халамжийн үйлчилгээний газарт нийгмийн халамжийн үйлчилгээг хэрэгжүүлэхэд зориулж 168.840.0 төгрөг олгоно. | | Гүйцэтгэлийн хувь | 100 | Орон нутгаас 168.454.2 төгрөгийг 2025 оны төсөвт тусган санхүүжилтийг бүрэн олгосон.<br>**Хэрэгжилтийн хувь 100** |
| 3.1 Гэр бүлийн тухай хууль, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулиар олгогдсон эрх, үүргийн хүрээнд орон нутагт дараах арга хэмжээг авч ажиллана. | | | | | |
| 3 | Гэр бүлийн тухай хуулийг хэрэгжүүлж орон нутагт угийн бичгийн хөтлөлтийн асуудлаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжин туслах багш ажиллуулан, орон нутгийн иргэдийн | - | Сургалтын тоо<br>Хамрагдсан иргэдийн тоо<br>Угийн бичиг хөтлөлтийн хувь | 56<br>5788<br>35.1 | Аймгийн Засаг даргын Тамгын газар, “Ураг удам уламжлалын Хонгор холбоо” төрийн бус байгууллагатай хамтран 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдөр “Өрх бүр – Угийн бичиг” сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулсан. Сургалт, зөвлөгөөнд нийт 250 хүн хамрагдсан бөгөөд угийн бичгийн түүхэн |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | угийн бичиг хөтлөлтийг зохион байгуулах | | | | уламжлал, гэр бүлийн хөгжил дэх үүрэг, өнөөгийн байдал болон цаашдын шинэчлэлийн чиг хандлага, угийн бичиг хөтлөөгүйгээс үүдэх хүндрэл бэрхшээл, түүнийг даван туулах арга замуудын талаар мэдлэгтэй болсон. Сум, багийн хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтнууд "Угийн бичиг хөтлөх арга зүй" сэдвээр 71 удаагийн сургалт зохион байгуулж сургалтад нийт 6012 иргэнийг хамруулан угийн бичиг хөтлөхийн ач холбогдлыг сурталчилсан.<br>Сумдын Засаг даргатай аймгийн Засаг даргын байгуулсан гэрээний хүрээнд соёлын төвүүдийн түшиглэн угийн бичгийн танхим байгуулахаар тусгасан. Хэрэгжилтийн хүрээнд 10 сумын соёлын төв танхим байгуулж, 24 ажил арга хэмжээ зохион байгуулан 663 хүн 40 гаруй өрхийг хамруулсан.<br>Аймгийн нийт өрхийн угийн бичиг хөтлөлт 40 хувьтай байна.<br>**Хэрэгжилтийн хувь 100** |
| Гэр бүлийн тухай хууль, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль,Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллийн тухай хууль, Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулиар олгогдсон эрх, үүргийн хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж ажиллана | | | | | |
| **3.1.2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд:** | | | | | |
| 4 | 3.1.2.1 Орон нутгийн гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх | 20,155.282 | тоо/хамрагдсан иргэдийн тоо<br><br>Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэргийн тоо/буурaлтын хувь<br><br>Зөрчлийн тоо/ бууралтын хувь | 28/ -9,6<br><br>258/+10 | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг дагаж гарсан 14 журмын хэрэгжилтийг ханган аймгийн 20 сумын хамтарсан баг, Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газартай хамтран 25 удаагийн сургалтаар 6251 иргэнд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулийн мэдээлэл олгох сургалтыг зохион байгуулсан.<br>Хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх хүрээнд "Хүүхэд, гэр бүлийн өмнө |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | | | | үүрэг хүлээгчид VI зөвлөгөөн", сумдад зохион байгуулсан "Хүүхэд, гэр бүлийн өмнө хүн бүр үүрэг хүлээгчид" сургалт , "Хамтын үнэ цэнэ" гэр бүлийн чуулган зэрэг 4 төрлийн арга хэмжээ зохион байгуулж нийт 9775 хүнд хүрсэн.<br>Үр дүн: Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн 2 гэмт хэрэг бүртгэгдэж өмнөх оны мөн үетэй харицуулахад 5 нэгжээр буюу 71,4 хувь , 147 зөрчил бүртгэгдэж 69 нэгжээр буюу 32 хувиар буурсан байна.<br>**Хэрэгжилтийн хувь 100** |
| 5 | 3.1.2.2. Гэр бүлд зөвлөгөө өгөх төвүүдийн үйл ажиллагааг өргөжүүлж, гэр бүлд сэтгэл зүйн тусламж үйлчилгээ, амьдрах ухааны боловсрол олгох | - | Гэрлэх ёслолын ордны дэргэдэх зөвлөгөө өгөх төвөөс сэтгэл зүй тусламж үйлчилгээ авсан гэр бүлийн тоо<br>Сум, багийн зөвлөгөө өгөх төвийн тоо/үйлчлүүлсэн гэр бүлийн тоо | 219<br><br>70 | "Гэр бүлд зөвлөгөө өгөх төв"-өөр дамжуулан 416 иргэнд анхан шатны уулзалт зөвлөгөөг өгсөн. Зөвлөгөө авахаар ирсэн иргэдийн 140 буюу 33.6% хүүхэд, 276 буюу 66.4% насанд хүрэгчид байна. Ганцаарчилсан сэтгэл зүйн зөвлөгөөнд нийт 416 хүн, хосын болон гэр бүлийн зөвлөгөөнд 108 хүн хамрагдсан байна.<br>Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх төвөөр үйлчлүүлсэн хүүхдүүдийн 15.7 хувь нь бэлгийн хүчирхийллийн хохирогч болон бэлгийн хүчирхийлэлд өртөх эрсдэлд амьдарч байгаа хүүхдүүд байна. Гэр бүлд зөвлөгөө өгөх төвөөр үйлчлүүлсэн насанд хүрэгчдийн 33.3 хувь гэр бүлийн хүчирхийлэл, 16.6 хувь архины хамаарал, 11.2 хувь үзэл бодлын зөрүүтэй байдал, 13 хувь гэр бүлийн гадуурх харилцаа, ажилгүйдэл болон эдийн засгийн байдал 17.4 хувь байна.<br>Зөвлөгөө өгөх төвөөс Гэр бүлийн боловсрол олгох сургалтад нийт 314 хүн хамрагдсан үүнээс 136 эрэгтэй, 178 эмэгтэй байна. Сургалтаар гэр бүлийн үүрэг хариуцлага, гэр |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | | | | бүлийн хүчирхийлэл, угийн бичиг хөтлөх арга зүй, хүмүүжлийн эерэг арга, гэр бүл төлөвлөлт, өрхийн төсөв сэдвээр мэдлэг олгосон. Аймгийн хэмжээнд Богд, Баянговь, Өлзийт, Заг, Гурванбулаг сум, Баянхонгор сумын 2, 3, 9 дүгээр багт байрлах гэр бүлд зөвлөгөө өгөх төвүүд тогтмол үйл ажиллагаа явуулж 89 гэр бүлд үйлчилгээ үзүүлсэн. **Хэрэгжилтийн хувь 100** |
| 6 | 3.1.2.3. Орон нутгийн жилийн төсвийн төсөлд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа, нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны урсгал зардал, хамтарсан багийн үйл ажиллагааны зардал, хохирогчид үйлчилгээнд шаардагдах зардлыг төсөвт тусгаж, батлуулах | 25,6 | Зарцуулсан төсвийн хэмжээ | 50 сая | Сумд хамтарсан багийн төлөвлөгөөг урьдчилан сэргийлэх, судалгаа мэдээллийн сан бүрдүүлэх, хамгаалал, хариу үйлчилгээ үзүүлэх гэсэн 3 зорилтын хүрээнд төлөвлөж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж, хагас, бүтэн жилээр тайлагнаж хэвшсэн. Дараах сумд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа, түүнд шаардагдах зардлыг шийдвэрлэсэн байна. Гурванбулаг сум 1.5 сая, Жаргалант сум 20.3 сая , Бууцагаан сум 10.0 сая, Бөмбөгөр сум 3.1 сая, Баян-Овоо сум 1 сая нийт 35.9 сая төгрөгийн төсөв батлуулан үйл ажиллагаанд зарцуулсан .<br>Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хүүхэд, эмэгтэйчүүдэд хамгааллын үйлчилгээ үзүүлдэг хүчирхийллийн эсрэг "Удвал төв" төрийн бус байгууллагатай Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газар 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр үйл ажиллагааны болон санхүүжилтийн гэрээг шинэчлэн байгуулсан. Тус төрийн бус байгууллага нь гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилт 19 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байна. Хүчирхийллийн эсрэг "Удвал төв" төрийн бус байгууллагын |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | | | | дэргэдэх нэг цэгийн үйлчилгээний төвд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 15 хүүхэд, 5 насанд хүрэгч хамгаалах байранд байрлан аюулгүй байдлын хамгаалалтын үйлчилгээнд 19, эмнэлгийн тусламж үйлчилгээнд 2, сэтгэл зүйн тусламж үйлчилгээнд 3, боловсролын үйлчилгээнд 2, нийгмийн халамжийн үйлчилгээнд 9 хүн хамрагдсан. Үйлчилгээ авсан хүүхэд, иргэдийг 100 хувь гэр бүлд нь эргэн нэгтгэсэн. Олгосон санхүүжилт 25,6 сая төгрөг байна<br>**Хэрэгжилтийн хувь 70** |
| 7 | 3.1.2.4. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр сургалт, мэдээлэл, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулах | 6.482.000 /Гэр бүлийн зардлаас/ | Зохион байгуулсан сургалт, нөлөөллийн ажлын тоо | 134 | Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор гэр бүл, хүүхдэд чиглэсэн тэмцээн уралдаан, нөлөөллийн 8 арга хэмжээ зохион байгуулж 1598 иргэдийг хамруулсан. Үүнд: “Хамтын үнэ цэн” гэр бүлийн чуулган, "Аз жаргалтай гэр бүл" марафон гүйлтийн уралдаан, "Эмээ, ээж би" хүндэтгэлийн арга хэмжээ, "Амин холбоо-100" , "Ээж Хүүгийн болзоо" эвент, "Харилцан хүндэтгэе" ,"Хамтарья Хэрэгжүүлье Хайрлая" өдөрлөг, "Хүүхэд, гэр бүлийн өмнө хүн бүр үүрэг хүлээгч" VI зөвлөгөөн байна<br>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийг бууруулах дэд зөвлөлийн төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлсэн. Төлөвлөгөөнд нийт 10 ажил арга хэмжээ тусган хэрэгжүүлж биелэлт 70 хувьтай байна. Төлөвлөгөөний хүрээнд эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхдүүдэд сэтгэл зүйн оношилгоо баривчлагдсан хүмүүжигч нарын зан үйлд эергээр нөлөөлөх, “Гэр бүлийн үнэ цэнэ”, “Хүүхдээ сонсъё, ойлгоё” зэрэг сургалт, |
| | | 1.500.000 /Баянхонгор сум / | Хамрагдсан иргэдийн тоо | 12472 | |
| | | Аймгийн ГХУСАЗСЗ-ийн зардлаас 25.2 сая төгрөг зарцуулсан | Сургалтад хамрагдсан өрхийн эзлэх хувь | 46 | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | | | | нөлөөллийн арга хэмжээ, "Үлгэрч өвөө" "Аюулгүй сонголт" хөтөлберт арга хэмжээнүүдийг үр дүнтэй зохион байгуулсан.<br>Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 30 хамтарсан баг нь урьдчилан сэргийлэх, хамгаалах, нөхөн сэргээх болон шуурхай тусламжийн үйлчилгээний хүрээнд нийт 151 удаагийн сургалт зохион байгуулж, 15,856 иргэнийг (6002 хүүхэд, 9854 насанд хүрэгч) хамруулсан үр дүнтэй байна.<br>Сургалтад нийт өрхийн 58 хувь хамрагдсан.<br>Үр дүн: Иргэдийн мэдлэг, хандлага сайжирч, үйлчилгээ авах боломж нэмэгдэн, хүчирхийллийг илрүүлэх, мэдээллэх, урьдчилан сэргийлэх ойлголт нэмэгдсэн.<br>**Хэрэгжилтийн хувь 100** |
| **3.1.3. Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 17 дугаар зүйл, 201 дүгээр зүйлийн 201.1,201.3, 201.7, 201.9, 201.10 дахь заалтын хэрэгжилтийг хангаж дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:** | | | | | |
| 8 | 3.1.3.1 Хүүхдийн эрх. хамгааллын салбар дундын төлөвлөгөө батлан хэрэгжүүлэх | - | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 90% | Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газар, Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Боловсролын газар, Эрүүл мэндийн газрууд хамтран "Хүүхдийн эрх, хамгааллын салбар дундын төлөвлөгөөг 7 чиглэлээр 29 ажил арга хэмжээг тусган боловсруулж батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж 95.2 хувьтай хэрэгжсэн.<br>"Салбар дундын үүрэг хүлээгчид, асран хамгаалагчдын хамтын ажиллагааг хангах хүрээнд "Хонгорын хүүхэд" хөтөлбөрийг боловсруулж 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 7/27 дугаар тогтоолоор батлуулав.<br>**Хэрэгжилтийн хувь 90** |
| 9 | 3.1.3.2. Төр хувийн | Хөгжил, | Хөгжлийн | **35** | Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газрын |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | хэвшлийн түншлэлийн хүрээнд хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний хүртээмжийг сайжруулж, хүүхдийн авъяас, чадварыг хөгжүүлэх | оролцооны зардлаас 15,132,900 төгрөг Урьдчилан сэргийлэхээс 7,373,300 төгрөг зарцуулсан. | үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн орон нутгийн нийт хүүхдэд эзлэх хувь | | дэргэдэх "Steam hub" хөтөлбөрт 200 хүүхэд, Биеийн тамир спортын газрын дэргэдэх спортын 9 төрлийн секцэд 228 хүүхэд, хүүхдийн Тэмүжин театрын дэргэдэх 4 төрлийн дугуйланд 119 хүүхэд, ерөнхий боловсролын сургуулийн дэргэдэх секц, дугуйланд нийт 9684 хүүхэд тус тус хамрагдаж байна. Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газраас хүүхдийн хөгжлийг дэмжих чиглэлээр зохион байгуулсан урлаг, спортын 10 төрлийн уралдаан тэмцээнд 3538 хүүхэд, Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын экепажийн хөгжлийн хөтөлбөрт 1000 хүүхдийг тус тус хамруулж нийт 14769 хүүхдийн хөгжлийг дэмжин, үйлчилгээний хүртээмжийг сайжруулж, авьяас чадварыг нь нээн хөгжүүлсэн. Энэ нь орон нутгийн нийт хүүхдийн 44.7 хувийг эзэлж байна. **Хэрэгжилтийн хувь 100** |
| 10 | 3.1.3.3. "Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих салбар зөвлөл"-ийн үйл ажиллагаанд шаардагдах төсвийг тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлуулах | Орон нутгийн төсөв 3.0 сая | Баталсан төсвийн хэмжээ | **3.0 сая** | Аймаг хөгжүүлэх 2025 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд 3.0 сая төгрөгийг тусган батлуулж дараах үйл ажиллагааг зохион байгуулсан. Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих орон тооны бус зөвлөлийг аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/704 дугаар захирамжаар байгуулан салбар дундын уялдааг ханган ажиллаж байна. Эрүүл мэндийн газрын дарга 2025 онд нарийн бичгээр томилогдон үйл ажиллагааны хэрэгжилтийг ханган ажилласан. Бага насны хүүхдийн хөгжлийн цогц бодлогыг хэрэгжүүлэх салбар дундын төлөвлөгөөнд 17 ажил арга хэмжээг тусган хэрэгжүүлсэн. "Сургуулийн өмнөх боловсролын өнөөгийн чиг хандлага" |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | | | | сэдэвт сургалт, туршлага солилцох ажлыг зохион байгуулж, 32 цэцэрлэгийн 77 багш хамруулан сургагч багшаар бэлтгэх үйл ажиллагаанд 3.0 сая төгрөгийг зарцуулсан. Бага насны хүүхдийн хөгжил, төлөвшил, эрүүл мэндийг дэмжих чиглэлээр 9 төрлийн сургалт арга хэмжээг зохион байгуулж 4240 хүүхэд, 2526 насанд хүрэгч хамрагдсан. **Хэрэгжилтийн хувь 100** |
| 11 | 3.1.3.4. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9 дүгээр заалтыг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах | 123,4 сая төгрөг | Байгууллагын тоо Зарцуулсан хөрөнгийн хэмжээ | 1<br>123,4 сая | Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9 дүгээр заалтыг хэрэгжүүлэх хүрээнд Өвгөнжаргалант хүүхдийн зуслангийн спорт талбайн тохижилтын ажлын гүйцэтгэгчээр "Базардарь" ХХК тендерт шалгарч 123.4 сая төгрөгөөр ажил гүйцэтгэж хүлээлгэн өгсөн. Тухайн аж ахуй нэгж хөнгөлөлт эдэлсэн. **Хэрэгжилтийн хувь 100** |
| 12 | 3.1.3.5. Аймгийн Хүүхдийн зөвлөл, хүүхдийн оролцооны байгууллагуудыг байр танхимаар хангах, шийдвэр гаргах түвшинд хүүхдийн оролцоог хангах ажиллах | - | Байр танхимаар оролцооны байгууллагын тоо | 2 | Хүүхдийн оролцооны 3 байгууллагыг Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газрын байранд өрөө танхимаар хanган ажиллалаа. Аймгийн Хүүхдийн зөвлөл, 20 сумын 32 сургуулийн хүүхдийн зөвлөл болон бусад 10 оролцооны байгууллагын гишүүдийг чадавхжуулах сургалтыг танхимаар 2, цахимаар 1 удаа зохион байгуулж арга зүйгээр ханган ажилласан. Тус хүүхдийн өөрийн удирдлагын байгууллагуудтай 18 арга хэмжээг зохион байгуулж танхимаар 4895, цахимаар 12,370 хүүхэд, залуучуудад хүрч ажилласан байна. Хүүхдийн оролцооны өөрийн удирдлагын байгууллагын төлөөлөгч хүүхдүүдийг Монголын хүүхдийн үндэсний чуулган, майхант цугларалт, Өсвөрийн парламент хөтөлбөр, аймгийн хүүхдийн |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | | | | нэгдсэн чуулганы үйл ажиллагаануудад оролцуулснаар шийдвэр гаргах түвшинд хүүхдийн оролцоог хангаж ажилласан болно.<br>**Хэрэгжилтийн хувь 100** |
| 13 | 3.1.3.6. “Олон нийтийн байцаагч"-ийг ажиллуулж, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлж, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлнэ | Орон нутгийн төсвөөс 32 сая төгрөг | Олон нийтийн байцаагчийн тоо | **20** | Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс 38 "Олон нийтийн цагдаа"-ийн орон тоог баталсан. Аймгийн хэмжээнд 22 олон нийтийн цагдаа гэмт хэрэг, зөрчил гарсан газар, ул мөрийг хамгаалах, оршин суугаа газрын хаягийг тогтоох, хэв журам сахих, нийтийн хэв журам хамгаалах талаар хууль сахиулах байгууллага болон бусад хуулийн этгээдээс зохион байгуулж байгаа ажилд оролцох зэрэг хууль тогтоомжоор заасан чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>**Хэрэгжилтийн хувь 100** |
| 14 | 3.1.3.7. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага үйл ажиллагаагаа хэвийн явуулахад тусламж, дэмжлэг үзүүлнэ | 130,0 сая | Арга хэмжээний тоо | 1 | Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар нь аймгийн засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн харьяанд үйл ажиллагаа эрхэлдэг. Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газрын дарга, мэргэжилтнүүдтэй уулзалт хийж салбарын анхаарах асуудлыг хэлэлцэн хамтын ажиллагаанд баримтлах зарчмыг тохиролцон мэргэжил арга зүйн зөвлөмж дэмжлэг өгч бодлогоор ханган ажиллаж байна. Орон нутгийн бодлогын баримт бичигт тусгах ажлын саналыг авч иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж хэвшсэн. Байгууллагын үйл ажиллагаагаа хэвийн явуулахад дэмжлэг үзүүлэх хүрээнд "Гэрлэх ёслолын ордон"-ыг Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газарт эзэмшүүлэн үйл ажиллагаагаа хэвийн явуулахад дэмжсэн |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | | | | Хүүхдийн байгууллагын 100 жилийн ойн арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлэх хүрээнд орон нутгаас 10.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ. Төрийн байгууллагуудыг хандивын үйл ажиллагаанд уриалан 120.0 сая төгрөгийг төвлөрүүлэн цуглуулж үйл ажиллагаанд зарцууллаа. **Хэрэгжилтийн хувь 100** |
| **3.1.4. Хүүхэд хамгааллын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 9 дүгээр зүйлийн 9.4, 9.8, 12 дугаар зүйлийн 12.5, 16 дугаар зүйлийн 16.1, 16.2, 26 дугаар зүйлийн 26.5, 27 дугаар зүйлийн 27.7, 31 дүгээр зүйлийн 31.1, 38 дугаар зүйлийн 38.1.1, 39 дүгээр зүйл, 40 дүгээр зүйлийн 40.1,40.2.7, 40.4, 40.6, 54 дүгээр зүйлийн 54.1.1, 54.1.3 дахь заалтын хэрэгжилтийг хангаж дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:** | | | | | |
| 15 | 3.1.4.1 Хүүхэд хамгааллын бодлогыг сурталчлан таниулж, салбар бүрд мөрдүүлэх | - | Хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлж буй байгууллагын тоо | 20 | Хүүхэд хамгааллын бодлогыг сурталчлах ажлын хүрээнд Хүүхэд хамгааллын тухай хуулийн 52.7 дахь заалтын дагуу байгууллагын нийт цалингийн сангийн нэгээс доошгүй хувьтай тэнцэх хэмжээний санг бүрдүүлж “Хүүхэд хамгааллын бодлого”-ыг хэрэгжүүлэхэд зарцуулах талаарх сургалт мэдээллийг 105 байгууллагын 2400 албан хаагчдад зохион байгуулсан. Аймгийн хэмжээнд хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлж буй 175 төрийн байгууллага, 23 аж ахуйн нэгж, байгууллага байна. **Хэрэгжилтийн хувь 90** |
| 16 | 3.1.4.2. Орон нутгийн хэмжээнд 2020-2024 онд хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан хүүхэд, үрчлэгдсэн хүүхэд, бүтэн өнчин хүүхдийн нөхцөл байдалд үнэлгээ хийж, мэдээллийн санд бүртгэх, шаардлагатай хүүхэд хамгааллын үйлчилгээг | 25,0 сая төгрөг | Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн тоо | 1877 | Орон нутгийн хэмжээнд 2020-2024 онд хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан хүүхэд 1200, үрчлэгдсэн хүүхэд 136, бүтэн өнчин 76 хүүхдийн нөхцөл байдалд үнэлгээ хийж 64 төрийн болон төрийн бус аж ахуй нэгжүүдэд хуваарилан, мэдээллийн санд бүртгэн ажилласан.<br>Тайлант онд Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн судалгаа мэдээллийг шинэчлэн гаргахад эрсдэлт нөхцөлд нийт 1877 байгаа нь нийт |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| 17 | бүрэн хүргэх | | | | хүүхдийн 5.6 хувийг эзэлж байна.<br>Эдгээр хүүхдүүдээс сургуулийн дэргэдэх хөгжлийн секц, дугуйланд 84, байгууллагаас зохион байгуулсан тэмцээн уралдаанд 57, Олон улсын Найрамдал цогцолборт 27, хүүхдийн театр, спортын төв ордны дэргэдэх секц, дугуйланд 56 хүүхэд, нийт 224 хүүхэд хамрагдаж байна. Энэ нь эрсдэлт нөхцөлд байгаа нийт хүүхдийн 11.9 хувийг эзэлж байна.<br>Эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа болон гэмт хэргийн хохирогч, холбогдогч 945 хүүхдийг хамгааллын үйлчилгээнд хамруулсан нь нийт эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн 50,3 хувийг эзэлж байна.<br>**Хэрэгжилтийн хувь 90** |
| 17 | 3.1.4.3. Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог шинэчлэн байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, шаардлагатай зардлыг орон нутгийн төсвөөс хуваарилж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч хүүхэд бүрд үйлчилгээг бүрэн хүргэх | 17.3 сая төгрөг | Хууль зүйн хорооны үйлчилгээ авсан хүүхдийн үйлчилгээ авах шаардлагатай нийт хүүхдэд эзлэх хувь | 94<br>5% | Аймгийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 09-ны А/210 дугаар захирамжийн дагуу хүүхдийн эрхийн хууль зүйн хороог шинэчлэн байгуулж төлөвлөгөөг батлуулан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч сэжигтэн 23, хохирогч 55, гэрч 10, зөрчлийн хохирогч 32, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан 4 нийт 94 хүүхдэд үйлчилгээ үзүүлж ажилласан. Хууль зүйн хорооны үйлчилгээ авсан хүүхдийн үйлчилгээ авах шаардлагатай нийт хүүхдэд эзлэх хувь 7.8 байна.<br>**Хэрэгжилтийн хувь 90** |
| 18 | 3.1.4.4. Хурдан морины уралдаан болон морины сунгаа, уралдааны бэлтгэлийн үед уралдаанч хүүхдийн эрх, амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангаж хяналт тавих | Төсөв- 11,200.000 /Хамгааллын зардал/ | Хяналт тавьж ажилласан уралдааны тоо<br><br>Бүртгэгдсэн уралдаанч хүүхдийн тоо | 25<br><br>1320 | Аймгийн хэмжээнд 2025 оны 5 сарын 01-ний өдрөөс эхлэн нийт бүсийн хурдан морины 5 уралдаан Галуут, Гурванбулаг, Баян-Өндөр, Шинэжинст, Баянхонгор сумдад зохион байгуулагдсан. Уралдааныг зохион байгуулж байгаа сумдын ЗДТГ, уяачдын холбоодод зөвлөмж хүргэж, сум тус бүрд уралдаанч хүүхдийн аюулгүй байдал, эрхийг хангахад |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| 19 | | | Хүүхдийн бэртэл гэмтлийн хувь | 5% | мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хяналт тавин ажиллаа.<br>Ардын хувьсгалын 104 жилийн ой, Хонгорын шигшмэл хурд, сумдын баяр наадамд уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг ханган ажилласан.<br>Тайлант онд нийт 27 зөвшөөрөлтэй уралдаанд 1011 уралдаанч хүүхэд бүртгэгдсэнээс 1 хүүхэд хөнгөн бэртсэн. Хүүхдийн бэртэл гэмтлийн хувь 0,09 байна<br>**Хэрэгжилтийн хувь 100** |
| 19 | 3.1.4.5. Гамшиг онцгой байдлын үед, ган зуд, үер усны улмаас хохирсон өрхийн судалгаа, мэдээллийг нэгтгэн гаргаж, салбар дундын хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх | - | Үйлчилгээ авсан өрхийн тоо, хүүхдийн тоо | 25<br>128 | Болзошгүй эрсдэл, байгалийн гамшиг, онцгой байдлын үед, ган зуд, үер усны улмаас хохирсон өрхийн судалгаа, мэдээллийг нэгтгэн гаргах, тэдэнд хамгааллын үйлчилгээ үзүүлэх салбар дундын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлсэн. Гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдалд өртсөн хүүхэд, гэр бүлийн судалгааг 2020-2025 онуудад гаргасан. Үүнд: 2020 онд 36, 2021 онд 64, 2022 онд 21, 2023 онд 5, 2024 онд 3, 2025 онд 2 хүүхэд, нийт 131 хүүхэд гамшгийн эрсдэлт нөхцөлд өртсөнөөс нас барсан хүүхдийн тоо 11. Гамшгийн эрсдэлд өртсөн хүүхэд бүрд хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх кэйс нээн ажилласан.Онцгой байдлын газартай хамтран зорилтот 25 гэр бүлд гамшгаас урьдчилан сэргийлэх, галын аюулгүй байдал, ахуйн осол гэмтэл, анхан шатны тусламж үзүүлэх чиглэлийн цогц сургалтыг зохион байгуулсан.<br>**Хэрэгжилтийн хувь 90** |
| 20 | 3.1.4.6. Хүүхдийн тоглоомын талбай, орон сууцны гэрэлтүүлэг, | - | Осол гэмтлийн буурсан хувь | - | Аймгийн Цагдаагийн газартай хамтран 45 тоглоомын төв, 3 PC тоглоомын төв, 5 дугуй засварын газар, 3 биллиардын төвд хяналт |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | цахилгаан сүлжээний аюулгүй байдал, замын далан, ухсан нүх, суваг, шуудуу, траншей, худаг орчимд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, шаардлагатай засвар үйлчилгээг хийх, анхааруулах тэмдэг байршуулж, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлнэ; | | | | шалгалтыг зохион байгуулсан. Хяналт шалгалтад хамрагдсан нийт 45 тоглоомын төвд тоглоомын аюулгүй байдлыг хангах, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх чиглэлээр зөвлөмжийг өгсөн. Баянхонгор аймгийн 30 хамтарсан баг болон хүүхдэд үйлчилгээ үзүүлдэг төрийн байгууллагуудад орон нутаг, байгууллагын ойр орчин, гудамжны гэрэлтүүлэг, цахилгааны аюулгүй байдал, ухсан нүх, траншей, худаг, замын хөдөлгөөний аюулгүй байдалд эрсдэлийн үнэлгээ, хяналт шалгалт хийх, зөрчлийг арилгаж хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх чиглэлээр ажлын чиглэл өгч ажилласан. 15 удаагийн хяналт шалгалтыг 56 аж ахуйн нэгжид зохион байгуулсан. Осол гэмтэл гараагүй байна.<br>**Хэрэгжилтийн хувь 100** |
| 21 | 3.1.4.7. Хүүхдийн хөгжлийн сургалтын төв, өдөр өнжүүлэх төв, хүүхэд харах үйлчилгээ, сүм хийд, худалдаа үйлчилгээний газар, амралт сувилал, аялал жуулчлалын газруудад хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгуулах | - | Хүүхдийн эрхийн зөрчил буурсан хувь | 5% | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 420 дугаар тогтоолоор батлагдсан хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсан 8 ажил арга хэмжээний биелэлт 89 хувь.<br>Төлөвлөгөөт хяналт шалгалтын тоо нийт 6 удаа зохион байгуулж, 243 байгууллага, аж ахуйн нэгжид хүрч ажилласан.<br>Хяналт шалгалтаар нийт илэрсэн 7 зөрчлийг арилгуулах зөвлөмжийг хүргэж ажилласан. Хүүхдийн эрхийн зөрчил 8% буурсан байна<br>**Хэрэгжилтийн хувь 100** |
| Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль,Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулиар олгогдсон эрх, үүргийн хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж ажиллана | | | | | |
| **3.2.1 Хөдөлмөрийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4, 15.6, 33 дугаар зүйлийн 33.1, 36 дугаар зүйлийн 36.1.3, 159 дүгээр зүйлийн 159.2 заалтын хэрэгжилтийг хангаж дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:** | | | | | |
| | 3.2.1.1. Зохистой хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг бий | - | Хамрагдсан салбар, аж ахуй нэгж | 50 | Зохистой хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор нийгмийн |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| 22 | болгохтой холбоотой Хөдөлмөрийн хуулийн зохицуулалтыг орон нутгийн хэмжээнд ажил олгогч, ажилтанд сурталчлан таниулах, хуулийн хэрэгжилтийг хангах; | | байгууллагын тоо | | түншлэгч талуудтай хамтран Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох эрх зүйн зохицуулалтын талаар аймгийн хэмжээнд дараах салбаруудыг хамруулан сургалт, сурталчилгааны 6 салбарын 67 аж ахуй нэгж байгууллага, 256 хувиараа хөдөлмөр эрхлэгчийг хамруулсан. Үүнд: Үйлдвэрлэл 14, Хөдөө аж ахуй 15, Барилга 11, Худалдаа, үйлчилгээ 5, Боловсрол 13, Эрүүл мэнд 9 Хувиараа хөдөлмөр эрхлэгч 256 байна.<br>Сургалтаар хөдөлмөрийн гэрээ, дотоод журам, цалин хөлс, ажил олгогч, ажилтны эрх үүргийн талаар мэдээлэл өгч, хууль зөрчихөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж өгсөн нь ажил олгогч, ажилтан хоорондын харилцааг сайжруулахад бодитой хувь нэмэр орууллаа.<br>**Хэрэгжилтийн хувь 100** |
| 23 | 3.2.1.2. Орон нутаг дахь бичил, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, ажил олгогчийн дэмжих хөдөлмөр эрхлэлтийн арга хэмжээг дэмжих (хөдөлмөрийн харилцааны хөтөлбөр)-ийн хэрэгжилтийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх; | 7 сая | Хамрагдсан аж ахуйн нэгж байгууллагын тоо | 5 | Хөдөлмөрийн харилцааны хөтөлбөрт “Далай ээж Баянхонгор” ХХК, “Сод баян” ХХК, Баянхонгор тээвэрчин ХХК, Кристаллс ХХК, Баялаг дулаан ХХК, Ган мөнхжин ХХК, Баянжаргант хүнс ХХК-уудыг сонгон, хөдөлмөрийн харилцааны чиглэлээр мэргэшсэн зөвлөхүүдийг ажиллуулж, хөтөлбөрийг хэрэгжүүлсэн<br>Зөвлөхүүд байгууллагын хөдөлмөрийн гэрээ, дотоод журам, ажил олгогч, ажилтны эрх үүрэг, эрх зүйн баримт бичгийн боловсруулалт зэрэгт дэмжлэг үзүүлж, хууль эрх зүйн хэрэгжилтийг сайжруулахад чиглэсэн арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. **Хэрэгжилтийн хувь 100** |
| | 3.2.1.3. Аймаг, нийслэлийн хөдөлмөр, нийгмийн | - | Хөдөлмөрийн сонирхлын болон | 10 | Хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| 24 | түншлэлийн гурван талт хороо, хөдөлмөрийн арбитр, хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллах; | | эрхийн маргааны тоо | | гурван талт хороонд ирсэн 11 өргөдлийг хүлээн авч, 12 удаа хуралдаж 100 хувь шийдвэрлэн ажилласан. Хөдөлмөрийн маргаанаас урьдчилан сэргийлэх зорилгоор Аймгийн үйлдвэрчний эвлэлийн холбоотой хамтран 13 удаагийн сургалтаар 20 аж ахуйн нэгжид зөвлөгөө өгч, хөдөлмөрийн эрх зүйн мэдлэг олгох мэдээлэл, арга зүйгээр ханган ажилласан. **Хэрэгжилтийн хувь 90** |
| 25 | 3.2.1.4. Аймаг, сумын хамтын хэлэлцээрийг байгуулах, хэлэлцээрийн биелэлтэд хяналт тавих, хэрэгжилтийг зохион байгуулахад санаачилгатай ажиллах; | - | Хөдөлмөрийн тухай хууль тогтоомжид нийцүүлж бүртгэсэн хэлэлцээрийн тоо | 5 | Аймгийн Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хороо 2025-2027 онд хэрэгжүүлэх хамтын хэлэлцээрийг хөдөлмөрийн харилцаа, хүн амын чанартай, хүртээмжтэй хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрлөх эрх, аюулгүй байдал, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зэрэг баримтлах чиглэлийг зохицуулан, хэрэгжүүлэхээр 7 бүлэг 50 заалтыг тусгаж байгуулан, хэрэгжилтийг ханган ажиллалаа.<br>Хамтын гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт тавьж 21 байгууллага, 6 сумд үзлэг, шалгалт хийж, 46 хамтын гэрээ, 7 хамтын хэлэлцээр нийт 60 гэрээ, хэлэлцээрийг бүртгэж, хөдөлмөрийн харилцааны ил тод байдал, түншлэлийг бэхжүүлэхэд анхааран ажиллаж байна. **Хэрэгжилтийн хувь 100** |
| **3.2.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсгийн хэрэгжилтийг хангах хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:** | | | | | |
| 26 | 3.2.2.1. 2025-2028 онд орон нутгийн хөгжилд ач холбогдолтой, орон нутгийн онцлогтой үйлдвэр, үйлчилгээний салбар, | | Бодлогын баримт бичгийн тоо<br>Судалгаа, мэдээллийн тоо | 1<br><br>1 | Аймгийн тэргүүлэх салбарууд болох уул уурхай, иргэний барилга, авто зам, хөдөө аж ахуй, хоол үйлдвэрлэл, орон байраар үйлчлэх үйлчилгээний чиглэлээр нийт 1194 ажлын |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | чиглэлийг тодорхойлж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ажил олгогчийн судалгааг гаргах, шаардлагатай дэмжлэгийн саналыг боловсруулах; | | | | байрны захиалга ирүүлсэн нь нийт ажлын байрны захиалгын 62.1 хувийг бүрдүүлж байна.<br>2025–2028 оны төлөвлөлтийн хүрээнд дээрх тэргүүлэх салбаруудад үүсээд буй ажиллах хүчний хомсдолыг бууруулах, хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах зорилгоор хөдөлмөрийн зах зээлийн нийлүүлэлт эрэлтийн уялдаа, сургалтын байгууллагуудтай хамтын ажиллагааг сайжруулах, ажлын байрны мэдээллийн ил тод байдал, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын ажиллах хүчний тогтвортой байдлыг дэмжих, бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулах зэрэг үе шаттайгаар зохион байгуулж, орон нутгийн хөдөлмөрийн нөөцийг нэмэгдүүлэх санал боловсруулж холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.<br>**Хэрэгжилтийн хувь 100** |
| 27 | 3.2.2.2. Орон нутгийн ажилгүйдэл, хөдөлмөр эрхлэлт, ядуурлын статистик мэдээлэл, бүртгэлтэй ажилгүй, ажлын байрны захиалга зэрэг захиргааны мэдээний чанарыг сайжруулах, тогтмол шинэчлэх; | | Судалгаа мэдээллийн тоо | 11 | Судалгаа мэдээллийн тоо 11 байна.<br>Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийг сар бүр өссөн дүнгээр боловсруулан, ажил хайгч иргэн, бүртгэлтэй ажилгүй иргэн, шинээр бий болсон ажлын байр, ажлын байрны захиалга, ажилд зуучлал зэрэг үндсэн үзүүлэлтүүдийн хүрээнд нэгтгэн гаргаж байна. Уг мэдээллийг аймгийн статистикийн албан ёсны тайлан, мэдээнд тогтмол хүргүүлж байгаа нь хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн үнэн бодит байдал, чанарыг сайжруулах, мэдээллийг цаг тухайд нь шинэчилж, бодлогын шийдвэр гаргахад нотолгоонд суурилсан мэдээллээр хангах чухал ач холбогдолтой ажил болж байна.<br>Бүртгэлтэй ажилгүй иргэд 2025 оны 11 дүгээр |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | | | | сарын байдлаар 141 иргэн бүртгэгдсэн ба өмнөх онтой харьцуулахад 626 буурсан үзүүлэлттэй байна.<br>2025 онд ажил олгогчдоос нийт 1194 ажлын байрны захиалга ирүүлсэн бөгөөд эдийн засгийн салбарын ангиллаар авч үзвэл хамгийн их эрэлттэй салбарууд болох хөдөө аж ахуй, уул уурхай, барилгын салбар нь нийт ажлын байрны захиалгын 62.1 хувийг эзэлж байна.<br>**Хэрэгжилтийн хувь 100** |
| 28 | 3.2.2.3.Орон нутгийн хүн амын бүлгүүд (эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, оюутан залуучууд зэрэг)-ийн хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл, ядуурлын нөхцөл байдлын судалгаа хийх, бүртгэл мэдээллийн сан үүсгэх, онцлог, хэрэгцээнд нь нийцсэн тусгайлсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх; | | 1. Аймгийн ажилгүйдэл, ядуурал, хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтийн тооны өсөлт, бууралтын хувь<br>2. Аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хэрэгжилтийн тооны өсөлтийн хувь<br>3. Аймгийн ажилгүйдэл, ядуурлыг бууруулах үйл ажиллагаанд төлөвлөсөн хөрөнгө, үйцэтгэлийн өсөлтийн хувь | Хүн амын бүлэг тус бүрээр судалгаа хийгдэж, бүртгэл мэдээллийн сан үүсэж, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. | Сүүлийн 4 жилд хөдөлмөр эрхлээгүй, хөдөлмөрийн насны хүн 1-5 хувь өсөж ажиллах хүчний оролцооны түвшин 71.0 хувьтай байгаа нь 4 жилийн өмнөх үеийн өсөлтийн дундажтай харьцуулахад тогтвортой байна.<br>Өнгөрсөн оны эцсийн байдлаар аймгийн хэмжээнд хөдөлмөрийн дутуу ашиглалт 6.1 хувьтай, Ажилгүйдлийн үргэлжлэх хугацаа 4-5 жил байна.<br>Хөдөлмөрийн эрхлэлтийн түвшин 2021 оноос 2024 он хүртэл 4.8 пунктийн өсөлттэй байгаа ч ажлын байрны тогтвортой өсөлтийг бий болгож чадахгүй, албан бус секторт хөдөлмөрлөх иргэдийн тоо нэмэгдэж байна.<br>Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэгт 55 ахмадад 300.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон.<br>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэмжлэгт 26 иргэнийг 200.0 сая төгрөгөөр дэмжиж үр дүнд 35 ажлын байр |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | | | | бий болсон.<br>25 ба түүнээс дээш насны, иргэн, аж ахуйн нэгж, бичил бизнес, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх хүсэлтэй 45 иргэнд нийт 450.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлснээр 203 ажлын байр шинээр бий боллоо.<br>Эдгээр арга хэмжээ нь зорилтот бүлгийн иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, өөрийн хөдөлмөрөөр амьжиргаагаа дээшлүүлэх нөхцөл бүрдүүлэхэд чухал хувь нэмэр оруулсан.<br>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээнд 2024 онд 1276 иргэн ажлын байраар хангагдаж, 2.835.480.880 төгрөгийг, 2025 онд нийт 895 иргэн хамрагдаж 1,668.9 сая төгрөгийг тус тус зарцуулсан ба өмнөх онтой харьцуулахад хамрагдсан хүн 29.9 хувиар, зарцуулсан мөнгөн дүн 41.1 хувиар тус тус бага байна.<br>**Хэрэгжилтийн хувь 100** |
| 29 | 3.2.2.4. Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн төлөв байдлыг эдийн засгийн үйл ажиллагааны салбар, ажил мэргэжлийн байдлаар нарийвчлан судлан тодорхойлж, хүний нөөцийн оновчтой төлөвлөлт, хуваарилалтын зохицуулалтыг хийж ажиллах; | | Судалгааны тоо<br>Шинээр ажлын байранд зуучилсан иргэдийн тоо | 1<br>600 | Аймгийн тэргүүлэх салбар болох уул уурхайн чиглэлд хөдөлмөрийн зах зээлийн эрэлт өндөр байгааг судалгаагаар тогтоосон. Судалгааны дүнг үндэслэн 5 уул уурхайн байгууллагаас 866 ажлын байрны захиалга авч 1567 ажил горилогчийг мэдээллийн санд бүртгэн сонгон шалгаруулалтад хамруулсан. Үүний үр дүнд 830 иргэнийг уул уурхайн салбарын ажлын байранд зуучилсан нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг бодитойгоор судлаж, хүний нөөцийн төлөвлөлтийг оновчтой зохион байгуулсан ажил болсон.<br>**Хэрэгжилтийн хувь 100** |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| 30 | 3.2.2.5 Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа авдаг хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай иргэний хөдөлмөр эрхлэх, аж ахуй эрхлэх хүсэл сонирхол, санал санаачилгыг бий болгох, дэмжих замаар халамжаас хөдөлмөрт шилжих бодлогын хэрэгжилтийг хангуулах; | 93.0 | Нийгмийн халамжийн авагчаас хөдөлмөр эрхлэгч болсон иргэний тоо<br>Холбогдох арга хэмжээний тоо<br>Төлөвлөсөн зарцуулсан хөрөнгийн хэмжээ | 40<br>2<br>90 сая | Нийгмийн халамжийн авагчаас 43 иргэн хөдөлмөр эрхлэгч боллоо. Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаанд хамрагддаг хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай иргэний хөдөлмөр эрхлэх, аж ахуй эрхлэх хүсэл сонирхол, санал санаачилгыг бий болгох 2 арга хэмжээг зохион байгуулан ажиллалаа. Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаанд хамрагддаг хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай 37 иргэнийг байнгын, түр ажлын байранд 36 иргэнийг зуучилсан. 93.0 сая төгрөг зарцуулсан<br>**Хэрэгжилтийн хувь 100** |
| 31 | 3.2.2.6. Орон нутагт албан бусаар хөдөлмөр эрхэлж байгаа иргэний мэдээллийг гаргах; | | Албан бусаар хөдөлмөр эрхэлж байгаа иргэний тоо | 9754 | Үндэсний статистикийн хорооны 2024 оны жилийн эцсийн мэдээгээр Баянхонгор аймагт хөдөө аж ахуйн салбарт 8900, хөдөө аж ахуйн бус салбарт 854 нийт 9754 албан бусаар хөдөлмөр эрхлэгч иргэн байна. Үүнээс 5793 нь эрэгтэй, 3961 нь эмэгтэй байна. 2025 оны статистик тархаагдаагүй байна.<br>**Хэрэгжилтийн хувь 100** |
| 32 | 3.2.2.7. Зохистой хөдөлмөр эрхлэлтийн бодлогод нийцэхгүй үйл ажиллагаа эрхэлж байгаа ААНБ, иргэний судалгааг гаргах, зөвлөмж өгөх; | | Зөвлөмжийн тоо | 1 | Зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрны нөхцөлийг сайжруулах зорилгоор аймгийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөлийн даргын 2025 оны 2/528 тоот албан бичгээр сумдын Засаг дарга нар, аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт зохистой хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлэх тухай зөвлөмжийг 19 сум, 52 аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүлж, хэрэгжилтийг хангахад хяналт тавьж, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллаж байна.<br>**Хэрэгжилтийн хувь 100** |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| 33 | 3.2.2.8 Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төв (Job center)-ийг орон нутагт нээн ажиллуулах, дэмжлэг үзүүлэх; | | 1. Ажилд зуучлуулсан иргэний тооны өсөлт<br>2. Холбогдох арга хэмжээний тоо | 2<br>2 | Аймгийн 2026 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд Job Center буюу хөдөлмөрийн биржийг шинээр байгуулах саналыг тусган ажиллаж, энэхүү ажлын хүрээнд 100 мкв талбай бүхий ажлын байрны засвар, тохижилтын бэлтгэл ажлыг үе шаттайгаар хангаж хэрэгжүүлж байна.<br>**Хэрэгжилтийн хувь 30** |
| 34 | 3.2.2.9.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүгийн дэмжлэг авсан ААНБ, ТББ, хувь хүн санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэх, ажлын байр бий болгосон эсэхэд хяналт тавих; | | Хяналт шалгалтын тоо<br>Судалгаа мэдээллийн тоо<br>Холбогдох арга хэмжээний тоо | 2<br>1<br>2 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас дэмжлэгт хамрагдсан байгууллагуудад шинэ ажлын байр бий болгосон эсэхэд 3 удаа хяналт шалгалтыг зохион байгуулан анхаарах асуудлын хүрээнд 2 зөвлөмж мэдээллийг боловсруулан аж ахуй нэгж байгууллагуудад хүргүүллээ.<br>Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа Сургалт, үнэлгээ, судалгааны институтын хамтарсан баг "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан"-гаас санхүүгийн дэмжлэгт хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан эсэх, ажлын байр шинээр бий болгосон байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажиллав. Энэхүү хүрээнд нийт 77 иргэний ажлын байранд очиж үнэлгээ өгч, хамтран ажилласан.<br>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагаанд 2 удаа дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж холбогдох мэргэжилтнүүдэд зөвлөмж өгч ажиллаж байна.<br>**Хэрэгжилтийн хувь 100** |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| 35 | 3.2.2.10.Техник технологийн хөгжил дэвшилд тулгуурласан бүтээмж өндөртэй, инноваци шингэсэн шинэлэг санал санаачилгыг дэмжих, холбогдох төрийн болон хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллахад нь дэмжлэг үзүүлэх; | 30.0 сая төгрөг | Холбогдох арга хэмжээний тоо<br>Арга хэмжээнд хамрагдсан хүний тоо<br>Төлөвлөсөн зарцуулсан хөрөнгийн хэмжээ<br>Шинээр бүртгүүлсэн патент/шинэ бүтээл, ашигтай загвар/-ын тоо | 2<br>2<br>30.0 сая | Техник технологийн хөгжил дэвшилд тулгуурласан бүтээмж өндөртэй, инноваци шингэсэн шинэлэг санал санаачилгыг дэмжих хүрээнд 52 иргэнийг хамруулан 2 удаагийн арга хэмжээ зохион байгууллаа<br>Инноваци шингэсэн шинэ санаа, гарааны бизнесийг дэмжих зорилгоор "Startup-2025" арга хэмжээг Startup Mongolia-тай хамтран амжилттай зохион байгуулж, нийт 13 багийн 52 залуучууд сургалт, ур чадварын хөтөлбөрүүдэд хамрагдав. Үүний үр дүнд 5 баг хурдасгуур хөтөлбөрт, 2 баг тус бүр 15.0 сая төгрөгийн санхүүжилт авч шалгарлаа.<br>Мөн Хангайн бүсийн шилдэг стартап шалгаруулах тэмцээнд Архангай, Өвөрхангай, Баянхонгорын 12 баг өрсөлдөхөд Баянхонгор аймгийн 2 баг 1, 3-р байранд шалгарч, нийт 35.0 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.<br>Шинээр бүртгүүлсэн патент/шинэ бүтээл, ашигтай загвар/ 4 бүртгэн авч үйл ажиллагааг эрчимжүүллээ.<br>**Хэрэгжилтийн хувь 100** |
| 36 | 3.2.2.11.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжилт авсан ААНБ, иргэдийн бараа бүтээгдэхүүнд борлуулалтын дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг шинэ түвшинд гаргаж, арга барилыг сайжруулж шинэчлэх, томоохон ААНБ-тай гэрээ байгуулж, борлуулалт хийх, хамтран ажиллах гарцыг бий болгох; | 54.988.000 төгрөг | Борлуулалтын дэмжлэгт хамрагдсан хүний тоо<br>Төлөвлөсөн, зарцуулсан хөрөнгийн хэмжээ | 50<br>55.0 сая | Борлуулалтын дэмжлэгт 114 иргэнийг хамруулсан.<br>"Баянхонгорт үйлдвэрлэв" нэрийн дэлгүүрийг тогтмол үйл ажиллагаатайгаар ажиллуулж, 2025 онд 4.8 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэв.<br>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжилт авсан ААНБ, иргэдийн бараа бүтээгдэхүүнийг олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор "Мөнхийн үсэг" компанитай хамтран цахим болон хэвлэмэл 600 ширхэг сэтгүүл бэлтгэн гаргав. "Намрын ногоон өдрүүд" үзэсгэлэн худалдаанд 74 иргэнийг оролцуулж, бараа бүтээгдэхүүнээ |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | | | | борлуулах боломжийг бүрдүүлэн 5.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. **Хэрэгжилтийн хувь 100** |
| 37 | 3.2.2.12. Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, дүүргийн зөвлөлийн чиг үүргээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллах; | ХЭДС | Холбогдох арга хэмжээний тоо | 5 | Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөл 1 удаа хуралдаж, орон нутагт хэрэгжүүлэх хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны бодлого, чиглэлийг 01 дүгээр тогтоолоор баталсан. Зөвлөл 5 удаагийн нөлөөллийн ажил зохион байгуулж, хэрэгжилт 100 хувь байна. **Хэрэгжилтийн хувь 100** |
| 38 | 3.2.2.13 Хөдөлмөрийн тухай хуулийн 144.3 дахь заалт, Ашигт малтмалын тухай хуулийн 43.3 дахь заалт, Ахмад настны тухай хуулийн 3 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангуулж, төвлөрсөн хөрөнгийг орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ажилгүйдлийг бууруулах үйл ажиллагаанд зориулалтын дагуу зарцуулах. | 397.2 сая төгрөг | Төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ<br>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгийн хэмжээ<br>бий болсон ажлын байр, ажилд зуучлагдсан хүний тоо | 16.5 сая төгрөг | Нийт 21.898.800 төгрөгийн хөрөнгө төвлөрүүллээ. Үүнээс Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд 397.2 сая төгрөг зарцуулсан. 2025 онд шинээр 143 ажлын байр бий болсон зэрэг үр дүнтэй байна<br>**Хэрэгжилтийн хувь 100** |
| **3.2.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.2, 25 дугаар зүйл, 32 дугаар зүйлийн 32.1.5 дахь хэсгийг хэрэгжүүлэх хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:** | | | | | |
| 39 | 3.2.3.1.Орон нутгийн түвшинд үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний шалтгааныг судалж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардагдах | - | Хамтарсан сургалтын тоо<br>Хамтарсан үзлэг, шалгалтын тоо | 15<br>30 | Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөнд 16 ажил, арга хэмжээг тусган баталж, хэрэгжилтийг ханган ажилласан.<br>Төлөвлөгөөний хүрээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч нартай хамтран |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | хөрөнгийг төлөвлөн, хэрэгжүүлэх, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн төрийн захиргааны хяналтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж. хамтран ажиллах; | | | | үзлэг, хяналтыг 37 байгууллагад, хамтарсан сургалт 21 зохион байгуулж 94 аж ахуйн нэгж байгууллагын байгууллагад хийж, осол, өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг уялдуулан хэрэгжүүлэхэд хамтран ажиллаж байна<br><br>Үйлдвэрлэлийн осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Улсын байцаагчийн 12 зөвлөмж, 8 төрлийн гарын авлагыг 120 аж ахуйн нэгж байгууллагад хүргэсэн. Үйлдвэрлэлийн осол өмнөх онтой харьцуулахад 2 дахин буурсан байна.<br>**Хэрэгжилтийн хувь 100** |
| 40 | 3.2.3.2. Аймаг, дүүргийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах, хувиараа, албан бус хөдөлмөр эрхлэгч, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч, малчдыг үйлдвэрлэлийн осол, аюултай, хортой хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаалах, сэрэмжлүүлэхэд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах; | 6 сая | ХАБЭА-н төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь<br><br>Төлөвлөсөн төсөв | 80<br><br>6 | Аймгийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн (ХАБЭА) салбар зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр 2025 онд Орон нутгийн төсвөөс 6.0 сая төгрөг зарцуулахаар баталсан.<br>2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг хангаж, биелэлт 96,6 хувьтай хэрэгжсэн.<br>ХАБЭА-н сарын аяны хүрээнд 11 томоохон ажлыг төлөвлөж, 100 хувийн хэрэгжилттэй гүйцэтгэсэн.<br>Нийгмийн түншлэлийн байгууллагуудтай хамтран 182 байгууллагын 1000 гаруй ажилтан, албан хаагчдад ХАБЭА-н сургалт зохион байгуулсан.<br>Сумдын ХАБЭА-н зөвлөлтэй хамтран хувиараа болон албан бус хөдөлмөр эрхлэгчид, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд зориулсан сургалтыг зохион байгуулж, 1300 гаруй малчин, 500 гаруй хувиараа хөдөлмөр эрхлэгчид хамрагдсан. |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | | | | Сургалтаар үйлдвэрлэлийн осол, аюултай, хортой хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаалах, урьдчилан сэргийлэх мэдлэг олгож, 2 ширхэг сэрэмжлүүлэх шторк бэлтгэн олон нийтэд хүргэсэн. Хэрэгжилтийн хувь 100 |
| 41 | 3.2.3.3.Хүний эрүүл мэнд, амь насанд ноцтой хохирол учруулсан үйлдвэрлэлийн томоохон осол, хурц хордлогын үед түүний хор уршгийг арилгахад чиглэгдсэн арга хэмжээ шуурхай авах. | - | Тухай бүр авсан арга хэмжээний тоо | 5 | Үйлдвэрлэлийн ослын талаарх 7 дуудлага, мэдээллийн дагуу аж ахуйн нэгж, байгууллагын ослын газар дээр шуурхай ажиллаж, хор уршгийг арилгах, ослын шалтгаан нөхцөлийг тодорхойлох, цаашид ижил төрлийн осол гаргуулахгүй байх чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл, зөвлөмж өгч ажилласан. **Хэрэгжилтийн хувь 90** |
| 3.2.4. **Ажиллах хүчний шилжилт, хөдөлгөөний тухай хуулийн 22 дугаар зүйл, 34 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:** | | | | | |
| 42 | 3.2.4.1.Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авсан тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа ажил олгогчтой бүртгэлтэй ажилгүй иргэнийг ажлын байранд дагалдуулан сургах, ажлын байраар хангах гэрээний хэрэгжилтэд хяналт тавих; | | Гадаад ажилтны тоо | 10 | Гадаадаас ажиллах хүч авах хүсэлт ирүүлсэн 2 аж ахуйн нэгжийн 60 ажлын байрны захиалгад 15 иргэнийг санал болгон, дагалдуулан сургах арга хэмжээ авч ажилласан. Дадлагажуулсан 15 хүн ажлын байранд тавигдах шаардлага хангаагүй тул аж ахуйн нэгжүүд гадаадаас ажиллах хүч авах хүсэлт гаргасан. **Хэрэгжилтийн хувь 100** |
| 43 | 3.2.4.2 Гадаад ажилтнаар хөдөлмөр эрхлүүлж байгаа ажил олгогчид зөвлөгөө өгөх, гадаад ажилтны хөдөлмөр эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн нөхцөл, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний | - | Гадаад ажилтан ажиллуулж байгаа байгууллагын тоо | 4 | Гадаадаас ажилтан авч ажиллуулж буй аж ахуйн нэгж байгууллагын гадаад ажилтны хөдөлмөр эрхлэлтэд хийх төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг 4 аж ахуйн нэгж байгууллагад хийж гүйцэтгэн 15 зөрчлийг илрүүлж аж ахуй нэгжүүдэд 2 заалт бүхий албан шаардлага хүргүүлсэн. |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалтыг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах | | | | **Хэрэгжилтийн хувь 100** |
| Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай хууль , Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Ахмад настны тухай хуулиар олгогдсон эрх үүргийн хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллана<br>3.3.1 **Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсэг болон холбогдох бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллана:** | | | | | |
| 44 | 3.3.1.1. Орон нутгийн иргэдэд нийгмийн даатгалын ач холбогдлыг сурталчлан таниулах, соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх замаар малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, залуучуудыг нийгмийн даатгалд хамруулах ажлыг Нийгмийн даатгалын байгууллагатай хамтран зохион байгуулах | 1.700.622.3 | Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулагчийн тооны өсөлтийн хувь | 10 | Өмнөх онд 5373 иргэнийг сайн дурын даатгалд хамруулсан бол 2025 онд нийт 6319 шинээр 350 иргэн сайн дурын даатгалд хамрагдаж 17.6 хувийн өсөлттэй байна.<br><br>Үүнээс: Сайн дурын даатгалд хамрагдсан малчдын тоо 4485, шинээр 218 малчин хамрагдсан байна<br><br>**Хэрэгжилтийн хувь 100** |
| 45 | 3.3.1.2.Нийгмийн даатгалын үйлчилгээг аймаг, дүүргийн иргэдэд шуурхай хүргэх зорилгоор нийгмийн даатгалын цахимжуулалтыг эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлэх | | Цахим хэлбэрт шилжүүлсэн тэтгэврийн хувийн хэргийн эзлэх хувь | 100 | Өмнөх онд 13069 тэтгэврийн хувийн хэрэг цахимжуулсан. 2025 оны жилийн эцсийн байдлаар 14115 тэтгэврийн хувийн хэргийг 430.132 зурган файл үүсгэн цахимжуулж 100 хувь цахимжуулсан байна.<br><br>**Хэрэгжилтийн хувь 100** |
| 46 | 3.3.1.3.Даатгуулагчийн нийгмийн баталгааг хангах хүрээнд ажил олгогч хуулиар хүлээсэн эрх, үүргээ биелүүлж нийгмийн даатгалын шимтгэлийн өр үүсэхгүй байх, өр үүссэн | | Нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй төсөвт байгууллагын тоо | 0 | Төсөвт байгууллагууд жилийн эцсийн байдлаар нийгмийн даатгалын шимтгэлийн өргүй байна.<br>**Хэрэгжилтийн хувь 100** |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | тохиолдолд нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөрийг шуурхай барагдуулахад Нийгмийн даатгалын байгууллагатай хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх | | | | |
| 47 | 3.3.1.4. Засгийн газрын 2023 оны 448 дугаар тогтоолоор баталсан "Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дүрэм"-ийн 8 дугаар зүйлийн 8.1 дахь хэсгийг хэрэгжүүлэх хүрээнд даатгуулагч, хүний эрүүл мэндийг хамгаалах, хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэхтэй холбоотой үйл ажиллагааг зохион байгуулах, аймаг, дүүргийн магадлалын зөвлөл, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй үйлчлүүлэх нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, орон нутгийн хэмжээнд хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулах, эмчлэн эрүүлжүүлэх, хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, урьдчилан сэргийлэхэд | | Хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн тоо | 2100 | Баянхонгор аймгийн хэмжээнд сүүлийн 4 жилийн хугацаанд нэгдүгээрт Сэтгэцийн өвчлөл, Хоёрдугаарт дотрын өвчлөл эрэмбэлэгдэж байна. Иймээс нэгдсэн эмнэлгийн сэтгэцийн эмч, Гэмтэл мэс заслын эмч, Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн нийгмийн эрүүл мэндийн ажилтантай хамтран ажиллаж осол аваар, Гэмтэл бэртэл, Артерийн даралт ихсэх өвчин тархинд цус харвах өвчин зэргээс урьдчилан сэргийлэх 50 удаагийн сургалт сурталчилгаанд 675 иргэнийг 19 сум, 4 өрхийн, 1 тосгоны нийгмийн эрүүл мэндийн ажилтан хамруулсан. 2024 онд гэмтэл мэс заслаар 126 2025 онд 132 хүн шинээр орсон байна. 2024 онд сэтгэц мэдрэлийн өвчний заалтаар 57 иргэн шинээр асаргаанд орсон байна.<br>**Хэрэгжилтийн хувь 90** |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллах; | | | | |
| 48 | 3.3.1.5.Хуримтлалын сангийн үйл ажиллагаатай холбогдуулан орон сууцжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх, холбогдох тооцоо судалгаа хийхэд хамтран ажиллах. | | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 1 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын бодлогын түвшинд зохион байгуулагдах ажил байна Уг ажилтай холбоотой хөтөлбөр, зөвлөмж, чиглэл тус газарт дээд газраас ирээгүй байна. **Хэрэгжилтийн хувь 30** |
| 3.3.2. **Нийгмийн халамжийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллана:** | | | | | |
| 49 | 3.3.2.1.Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг шинэчилсэн журмын хүрээнд үзүүлэх, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хяналт тавьж хамтран ажиллах; | 39.0 сая төгрөг | Аж ахуй нэгж байгууллагын тоо | 6 | Орон нутагт хэрэгжих боломжтой эрэлт хэрэгцээтэй 6 үйлчилгээг сонгож, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг гэрээлэн гүйцэтгэх 6 аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулж, гэрээ байгуулан ажиллаж байна. 2025 онд 83 иргэнд үйлчилгээг үзүүлэн ажилласан. **Хэрэгжилтийн хувь 100** |
| 50 | 3.3.2.2.Олон нийтийн оролцоонд түшиглэсэн Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах үйлчилгээнд согтууруулах, мансууруулах бодис хэрэглэдэг өрхийг | 13,6 сая төгрөг | Үйлчилгээнд хамрагдсан хүний тоо, үүнээс хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг өрхөөс шинээр хөдөлмөр эрхэлсэн иргэний тоо | 150<br>20<br>3 | Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах үйлчилгээг Нийгмийн түншлэл төрийн бус байгууллагатай гэрээлэн гүйцэтгэж тус үйлчилгээнд 401-ээс доош оноотой 50 өрхийн 240 иргэн хамрагдаж 15 иргэн шинээр хөдөлмөр эрхэлж байна. **Хэрэгжилтийн хувь 100** |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | хамруулах. | | | | |
| 51 | 3.3.2.3.Орон гэргүй эсхүл архинд донтсон иргэдийг нийгэмшүүлэх, донтолтоос ангижруулах арга хэмжээг орон нутагтаа холбогдох талуудыг оролцуулан зохион байгуулах, архинаас гаргах дэмжих бүлгүүдийг ажиллуулахад дэмжлэг үзүүлэх. | 300.0 сая | Дэмжих бүлгийн тоо | 2 | "Жаргалтай амьдрал" Сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний төвтэй хамтран архины донтолттой буюу F10 оноштой иргэдэд 15 өдрийн клиник, сэтгэлзүй, нийгмийн үйлчилгээний сэргээн засах үндсэн хөтөлбөр болон архаг ядаргаа, стрессийн хөтөлбөр хэрэгжүүлж 105 иргэнийг хамруулсан. "Архинд донтох эмгэгтэй иргэдийг нөхөн сэргээх хамтарсан хөтөлбөр"-ийг 2 удаа зохион байгуулж 53 иргэнийг 3 дэмжих бүлгийн хүрээнд нөхөн сэргээх үйлчилгээнд хамруулж, архинд донтох эмгэгтэй иргэдийн сэргэх, дахин согтууруулах ундааны хэрэглээнээс татгалзахад нь дэмжлэг үзүүлсэн. **Хэрэгжилтийн хувь 90** |
| 52 | 3.3.2.4. Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх толгойлсон, олон хүүхэдтэй өрхийн амьжиргааг дэмжих үр дүнтэй арга хэмжээг орон нутгийн онцлогт тохируулан зохион байгуулах | 15.0 сая төгрөг | Хүрч ажилласан өрх толгойлсон өрхийн тоо | 50 | Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний 0-18 хүртэл насны 3 буюу түүнээс дээш олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн нийгмийн оролцоог дэмжих сургалтын үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг нь дэмжих үйлчилгээ үзүүлэх байгууллагаар "Оюун тэлэхүй" ТББ шалгарч 15.0 сая төгрөгийн гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. Өрх толгойлсон 50 өрхтэй ажиллаж тэдний амьдралын чанарыг дээшлүүлэх, санхүүгээ хэрхэн удирдах, орлогын эх үүсвэртэй болгох зэрэг өрхийн амьжиргаанд нь нөлөөлөх нөлөөллийн ажлуудыг хийж хэрэгжүүлж ажиллаж байна. **Хэрэгжилтийн хувь 100** |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| 53 | 3.3.2.5.Нийгмийн ажилтнуудын бусад салбарын ажилтнуудтай хамтран ажиллах ажлын уялдаа холбоог сайжруулах, чадавхжуулах сургалтад тогтмол хамруулах. | 15,2 сая төгрөг | Арга хэмжээ сургалтын тоо | 2 | Баянхонгор аймгийн хэмжээнд 20 сум 10 багт хүүхэд гэр бүлийн нийгмийн ажилтныг 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдрөөс томилон ажиллуулж байна. Нийгмийн ажилтнуудыг ажлын байрандаа хөгжих, хүүхэд хамгааллын болон хөгжлийн үйлчилгээг олон нийтэд хүртээмжтэй хүргэх ажлын хүрээнд 4 удаагийн чадавхжуулах сургалтаар идэвхжүүлж, 14 хоног тутам кейс хэлэлцүүлэг зохион байгуулж, долоо хоног бүрийн Баасан гарагт цахим уулзалтыг тогтмол зохион байгуулж байна. **Хэрэгжилтийн хувь 100** |
| 3.3.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаар | | | | | |
| 54 | 3.3.3.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, хөгжлийн бэрхшээлийн талаарх олон нийтийн ойлголт хандлагыг нэмэгдүүлэх мэдээлэл, сурталчилгааны ажлыг бүх шатны төлөвлөгөөнд тусгах, шаардагдах хөрөнгийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж, орон нутгийн жил бүрийн төсөвт тусган, хэрэгжилтийг ханган ажиллана; | 20.0 сая төгрөг | Дэмжлэг үзүүлсэн хөрөнгийн хэмжээ | 20.0 сая | Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил"-ийн ажлын төлөвлөгөөг гарган хэрэгжилтийг хангаж ажилласан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж, хөнгөлөлтөд 130 иргэнийг хамруулж, 62.9 сая төгрөг зарцуулсан. Хөгжлийн бэрхшээлтэй хувиараа хөдөлмөр эрхлэх хүсэлтэй 50 иргэнийг зээлийн өмнөх болон дараах сургалтад хамруулж 2.3 сая төгрөг зарцуулсан.<br>Хөгжлийн бэрхшээлтэй 26 хувиараа хөдөлмөр эрхлэгчийн төслийг дэмжиж 200.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгт хамруулсан.<br>Хөгжлийн бэрхшээлтэй 1263 иргэнд 2910.5 сая төгрөгийн тэтгэврийг хугацаанд нь олгож ажиллалаа.<br>Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус салбар зөвлөл нэг удаа хуралдаж 2025 онд хэрэгжүүлэх ажлын |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | | | | төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 24 ажил арга хэмжээг тусган батлуулж, хэрэгжилтийг ханган ажилласан. Арга хэмжээг хэрэгжүүлэхэд Орон нутгийн төсвөөс 20.0 сая төгрөг баталсан. **Хэрэгжилтийн хувь 100** |
| 55 | 3.3.3.2 Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах. | | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 1 | Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэлээр 2 удаа сургалт зохион байгуулж, 38 хөгжлийн бэрхшээлтэй хүн хамрагдсан. **Хэрэгжилтийн хувь 100** |
| 56 | 3.3.3.3 Нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох сургагч багш бэлтгэн, орон нутгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сургалтад хамруулах | | Зохион байгуулсан сургалтын тоо | 26 | Сум өрхийн эрүүл мэндийн төвийн 24 нийгмийн эрүүл мэндийн ажилтнуудыг нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр чадавхжуулан сургасан. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг эх хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд ээлтэй болгох зорилгоор Эм-Си-Эс групптэй хамтран Төрөх эмэгтэйчүүдийн тасагт иж бүрэн засвар, тоног төхөөрөмжийн хангалт хийхээр 6.682.591.988 төгрөгийн зураг төсөв хийгдэж, Эрүүл мэндийн яамтай гэрээ байгуулахаар ажиллаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй 6 иргэнийг нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох сургалтад хамрууллаа. **Хэрэгжилтийн хувь 100** |
| 57 | 3.3.3.4 Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэх дэмжих төвийг байгуулах | | Дэмжих төв | 1 | "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуучуудын хөгжлийн төв" ТББ нь тендерт шалгаран дэмжих төв 1 байгуулагдан үйл ажиллагаанд 20 хүүхдийг хамруулан ажиллаж байна. Тус оны 11 дүгээр сарын гүйцэтгэлээр 0-16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | | | | хүүхдийг асарч байгаа 384 иргэнд 1,208,0сая төгрөг, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй 395 хүүхдэд 1.359.1 сая төгрөгийн тэтгэмж, 52 хүүхдэд 13.9 сая төгрөгийн тусгай хэрэгсэл тус тус олгосон байна.<br>Мөн хөгжлийн бэрхшээлтэй 14 хүүхдэд Хөгжлийн дэмжлэгийн төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.<br>**Хэрэгжилтийн хувь 100** |
| 58 | 3.3.3.5. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрмийн 1.10, 2.5, 2.7, 3.3.7, 3.3.8, 6.1-ийн хэрэгжилтийг хангаж ажиллана; | 5.0 сая төгрөг | Гүйцэтгэлийн хувь | 100 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс нь Засаг даргын 2024 оны 04 дүгаар сарын 01-ны өдрийн А/212 тоот захирамжаар 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. Тус комисс нь 2025 онд 16 ажил, арга хэмжээ төлөвлөсөн 100 хувьтай хэрэгжсэн байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөл, олон талт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагаанд зориулан 5,0 сая төгрөг зарцууллаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын хурал нь 2025 онд 21 хурал төлөвлөснөөс 21 удаа хуралдсан.<br>**Хэрэгжилтийн хувь 100** |
| 59 | 3.3.3.6. Салбар комиссын үйл ажилагааны зардлыг орон нутгийн төсөвт тусгах, албан байраар болон гишүүдийн ажиллах нөхцөлийг хангаж, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, хүүхдийн | 5.0 сая төгрөг | Гүйцэтгэлийн хувь | 100 | Салбар комисс нь 2025 онд 16 ажил, арга хэмжээ төлөвлөсөн 100 хувьтай хэрэгжсэн байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөл, олон талт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагаанд зориулан 5,0 сая төгрөг зарцууллаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | хөгжлийн хоцрогдол, бэрхшээлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах зэрэг шаардлагатай дэмжлэг, туслалцааг үзүүлнэ; | | | | эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын хурал нь 2025 онд 21 хуралдсан. Энэхүү комиссын үйл ажиллагаа нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ордонд тусгай тохижуулсан өрөөнд зохион байгуулагддаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрмийн 6.1-ийн дагуу хэлсээр ажиллах гэрээ байгуулсан. "Дата өгөгдөлд дүн шинжилгээ хийх" арга зүйн сургалтад салбар комиссын 5 гишүүнийг хамруулан чадавхжууллаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 36 үзүүлэлт үзүүлэлтээр дашбоурд үүсгэн тогтмол шинэчлэн хөтлөн ажиллаж байна. **Хэрэгжилтийн хувь 100** |
| 60 | 3.3.3.7. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөлийн үйл ажиллагаанд шаардлагатай төсвийг шийдвэрлэн, дэмжлэг үзүүлж ажиллана; | 1.0 сая төгрөг | Дэмжлэг үзүүлсэн хөрөнгийн хэмжээ | 1.0 сая | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдрийн арга хэмжээнд аймгийн Засаг даргын Тамгын газраас удирдамж, хөтөлбөр боловсруулж сумд руу мэдээлэл хүргэж ажилласан. Мөн спортын тэмцээний арга хэмжээнд спорт заал болон өргөмжлөл хэвлэлтэд дэмжлэг үзүүлэн ажилласан. 2025 оны 12 дугаар сарын 03-ний өдөр зохион байгуулагдсан. Урлагийн тоглолтод 100ш билет авч борлуулан хамтран ажилласан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог нэмэгдүүлэх анхаарч ажиллаа. Номгон сургуулийн хажуугийн төв замын явган хүний гарцын хэсэгт дуут дохио бүхий тэмдэглэгээ байршууллаа. **Хэрэгжилтийн хувь 100** |
| 61 | 3.3.3.8.Орон нутгийн гамшгаас хамгаалах, онцгой байдлын үед авах арга хэмжээг хөгжлийн | | Арга хэмжээний хэрэгжилтийн тоо | 1 | Орон нутгийн гамшгаас хамгаалах, онцгой байдлын үед авах арга хэмжээг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ шаардлагыг тусган боловсруулж, гамшгаас урьдчилан |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | бэрхшээлтэй хүний хэрэгцээ шаардлагыг тусган боловсруулж, хоргодох байрны хүртээмжийг нэмэгдүүлэх | | | | сэргийлэх төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хэрэгжилтийн хувь 95,6 хувьтай байна. Тус төлөвлөгөөнд гамшгийн үед болон гамшгийн дараа хөгжлийн бэрхшээлтэй хүний бэрхшээлийн хэлбэрт нийцсэн арга хэмжээг төлөвлөн ажиллаж байна. **Хэрэгжилтийн хувь 100** |
| 62 | 3.3.3.9. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчийн хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, хүүхдээ нийгмийн идэвхтэй гишүүн болгоход чиглэсэн чадавхжуулах хөтөлбөр хэрэгжүүлэх | | Зохион байгуулсан арга хэмжээний тоо. | 2 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчийн хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, хүүхдээ нийгмийн идэвхтэй гишүүн болгоход чиглэсэн сургалтыг Японы хүүхдийг ивээх сан санхүүжилтээр хэрэгжүүлж буй "Тэгш хүртээмжтэй, цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь" төслийн хүрээнд 6 удаагийн сургалтыг зохион байгуулж 430 иргэнийг хамрууллаа. **Хэрэгжилтийн хувь 100** |
| 63 | 3.3.3.10.Засгийн газрын 2022 оны 253 дугаар тогтоолоор баталсан "Хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулаагүй орон тоо тутамд ногдох төлбөрийг хөнгөлөх, чөлөөлөх журам"-ыг хэрэгжүүлж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авсан ажил олгогчийг дэмжих, төлбөрийг хөнгөлөх, чөлөөлөх арга хэмжээг хэрэгжүүлж, мэргэшсэн | 75.5 сая төгрөг | Байгууллага аж ахуй нэгжийн тоо | 3 | Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн хороо, аймгийн ажил олгогч эздийн холбоотой хамтран ажиллаж байна.<br>Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангах хүрээнд 25-аас дээш ажилтантай 8 байгууллагад үзлэг хийж 21.9 сая төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлсэн. 25 ба түүнээс дээш ажилтантай 81 байгууллагад судалгаа хийж 23 байгууллагад зөвлөмж хүргүүлсэн. Үүний үр дүнд 3 аж ахуйн нэгж 9 хөгжлийн бэрхшээлтэй иргэний үйлдвэрлэсэн нийт 75.5 сая төгрөгийн бараа, бүтээгдэхүүнийг худалдан авсан. **Хэрэгжилтийн хувь 100** |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | төрийн бус байгууллагуудаар аж ахуйн нэгж, байгууллагад зөвлөгөө өгөх, хэрэгжилтэд хяналт тавих ажлыг гүйцэтгүүлнэ; | | | | |
| 64 | 3.3.3.11. Нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлж байгаа бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцод нийцэж байгаа эсэхийг судлан Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хорооноос ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулна; | | Зохион байгуулсан сургалтын тоо:<br>Сургалтад хамрагдсан иргэдийн тоо: | 1<br>30 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор нэгдсэн эмнэлгийн шинэ барилгад үнэлгээ хийхэд налуу зам, бие засах өрөө, коридорын бариул, резинэн зам, бусад нэн шаардлагатай туслах хэрэгслээр хангагдсан байдал 60 хувьтай байна. Улсын жишиг амбулаторийн барилга ашиглалтад орж байгаатай холбогдуулан аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамгаалах орон тооны бус салбар зөвлөлөөс хараны бэрхшээлтэй иргэдэд зориулсан резинэн зам, сонсголын бэрхшээлтэй иргэдэд зориулсан цахилгаан шатны дуут санамжийг стандартын дагуу хийх зөвлөмжийг өгч, хэрэгжилтийг хангуулсан. Өлзийт сум, Шаргалжуут тосгоны эрүүл мэндийн төвүүд баррель үсгийн хаягжилтыг стандартын дагуу хийсэн. Аймгийн нэгдсэн эмнэлэгт эмэгтэйчүүдийн умайн хүзүүний хавдар илрүүлэх ухаалаг тоног төхөөрөмжөөр хангагдсан. Ингэснээр нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийг хавдраас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх нөхцөл боломж бүрдсэн. Хагас жилийн байдлаар давхардсан тоогоор 60 эмч, ажилтнуудыг чадавхжуулах сургалтад хамруулсан. "Тэгш хүртээмжтэй, цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь" төслийн хүрээнд 16-р цэцэрлэг, Баян-Өйт цогцолбор сургууль, Энхбүрд, Оточ |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | | | | мандал өрхийн эрүүл мэндийн төвүүдэд ээлтэй орчин бүрдүүлэх хүрээнд завсар тохижилт хийгдлээ. **Хэрэгжилтийн хувь 100** |
| 65 | 3.3.3.12 Цахим хуудас, телевиз, нийгмийн мэдээллийн хэрэгслийн хүртээмжийг сайжруулах арга хэмжээ авч, 2-оос доошгүй мэргэжлийн дохионы орчуулагчийг бэлтгэн ажиллуулна; | 26.3 сая төгрөг | Хүртээмжтэй хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, цахим хуудасны тоо | 1 | Мэдээллийн хэрэгслийн хүртээмжийг сайжруулах хүрээнд орон нутгийн 1 телевизэд хүсэлт хүргүүлсэн. Ерөнхий боловсролын Номгон сургуульд 1 дохионы мэргэжлийн багш ажиллуулж байна. Японы хүүхдийг ивээх сангийн дэмжлэгээр 23 багшийг дохионы хэлмэрчээр бэлтгэсэн. Дээрх багш нар 3 удаагийн сургалт зохион байгуулж 68 төрийн албан хаагч хамрагдсан. **Хэрэгжилтийн хувь 70** |
| 66 | 3.3.3.13 Төрийн үйлчилгээний байгууллагын барилгын гадна байгууламжийн дотор талын хүртээмжийг сайжруулах | | Үүнээс: эхний ээлжид НДГ, ХХҮГ, ХГБХХГ, нэг цэгийн үйлчилгээний төв | 3 | Аймгийн хэмжээнд төрийн 198 байгууллага гадна болон дотор орчны тохижилтыг сайжруулж, иргэдэд тав тухтай үйлчилгээ авах орчин нөхцөлийг бүрдүүлсэн. Хүний эрхийн комисстой хамтран Хөгжлийн бэрхшээлтэй хүнд ээлтэй орчин бүрдсэн эсэх үнэлгээг хийж нэгтгэлээр 85,6 хувьд хүртээмжтэй орчин бүрдсэн үнэлгээг авсан. Нийгмийн даатгалын газар, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газар, Нэг цэгийн үйлчилгээний төвийн барилгын гадна байгууламж болон дотор талын хүртээмж 100 хувь хангагдсан **Хэрэгжилтийн хувь 100** |
| 67 | 3.3.3.14. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын | УС-ээс 170,000 төгрөг ХХО- | Жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн хувь | 89 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс нь иргэний нийгмийн байгууллагуудтай дараах байдлаар хамтран |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | салбар комисс, Хүүхдийн төлөө зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлж, орон нутгийн шийдвэр гаргах түвшинд хүүхэд, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэн зэрэг нийгмийн бүлгүүд, иргэний нийгмийн байгууллагыг дэмжиж бодит оролцоог ханган, салбар дундын уялдаа холбоог сайжруулна. | 26,757,200 төгрөг н | | | ажилласан. Үүнд:<br>-Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй өрхөд үзүүлэх олон нийтийн оролцоонд түшиглэсэн үйлчилгээг "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудын хөгжлийн төв" үзүүлэхээр гэрээ байгуулан ажиллаж байна. хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх олон нийтэд түшиглэсэн халамжийн "Насны баясгалан оч" ТББ-аар гэрээлэн гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулан 40 иргэнд 9 сая төгрөгийн санхүүжилт олгосон, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өдрийн үйлчилгээг "Сахиусан тэнгэр" ХХК-иар гэрээлэн гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулан 20 иргэнд 7 сая төгрөгийн санхүүжилт олгосон.<br><br>Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 4 чиглэлийн хүрээнд 25 арга хэмжээг тусган хэрэгжүүлснээр 17327 хүүхэд, 9872 насанд хүрэгчдэд хүрч ажилласан байна. Хүүхдийн төлөө зөвлөл нь 4 удаа хуралдсан. Төлөвлөгөөний биелэлт 95,6 хувьтай байна<br>**Хэрэгжилтийн хувь 90** |
| **3.3.4 Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 20 дугаар зүйл хэрэгжилтийг хангаж дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:** | | | | | |
| 68 | 3.3.4.1.Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд иргэдэд гэр бүлийн боловсрол олгох, жендэрт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр сургалт, мэдээлэл, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг Гэмт | Орон нутгийн төсөвт хөрөнгөөр | Сургалт мэдээллийн тоо | 7 | Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, бууруулах чиглэлээр сургалт нөлөөллийн ажлуудыг үе шаттайгаар зохион байгууллаа. "Хүүхэд, гэр бүлийн өмнө үүрэг хүлээгчид VI зөвлөгөөн", "Аз жаргалтай гэр бүл" марафон гүйлтийн уралдаан, "Эмээ, ээж би" хүндэтгэлийн арга хэмжээ, "Амин холбоо-100" , "Ээж Хүүгийн болзоо" эвэнт, "Харилцан хүндэтгэе" |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрыг түшиглэн зохион байгуулна | | | | ,"Хамтарья-Хэрэгжүүлье-Хайрлая" өдөрлөг, "Хүүхэд, гэр бүлийн өмнө хүн бүр үүрэг хүлээгчид" нэгдсэн 8 арга хэмжээ зохион байгуулж нийт 3318 иргэн хамрагдсан. Урьдчилан сэргийлэх нөлөөллийн ажил зохион байгуулсны үр дүнд гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчил өмнөх оны мөн үед 4 байсан бол энэ онд 1 болж 75 хувиар буурсан үр дүнтэй байна. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн хурлаар хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийг бууруулах дэд зөвлөлийн төлөвлөгөөг 10 ажил арга хэмжээ тусган батлуулсан. Төлөвлөгөөний биелэлт 90 хувьтай байна . Эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхдүүдэд сэтгэл зүйн зөвлөгөө оношилгоо, баривчлагдсан хүмүүжигч нарын зан үйлд эергээр нөлөөлөх, "Гэр бүлийн үнэ цэнэ", "Хүүхдээ сонсъё, ойлгоё" зэрэг сургалт, нөлөөллийн ажил, "Үлгэрч өвөө" "Аюулгүй сонголт" хөтөлбөрт арга хэмжээнүүдийг зохион байгуулсан. **Хэрэгжилтийн хувь 100** |
| **3.3.5. Ахмад настны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллана:** | | | | | |
| 69 | 3.3.5.1.Ахмад настны тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжид сургалт, сурталчилгаа хийх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд чиглэсэн нөлөөллийн ажил зохион байгуулах; | 2,5 сая | Сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажлын тоо | 2 | Төрийн байгууллагуудын ахмадын зөвлөлүүдтэй хамтран 275 ахмад настанд Ахмад настны тухай хуулийн шинэчилсэн найруулгын талаарх сургалт мэдээлэл хийсэн. Ахмадын хороотой хамтран 2 удаагийн нөлөөллийн ажил зохион байгуулан ажилласан. Аймгийн ахмадын хороо Баянбулаг, Галуут, Өлзийт, Заг, Эрдэнэцогт, Жинст зэрэг сумдад ажиллаж Ахмад настны тухай хуулийн шинэчилсэн найруулгын |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | | | | талаарх сургалт мэдээлэл хийлээ. **Хэрэгжилтийн хувь 100** |
| 70 | 3.3.5.2.Ахмадын сан байгуулан ажиллуулах, тэтгэвэрт бэлтгэх төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд ААНБ-тай хамтран ажиллах, хяналт тавих. | 5,6 сая төгрөг | 1.Ахмадын сан байгуулсан байгууллагын тоо, | 10 | Аймгийн хэмжээнд 17 байгууллага ахмадын сан байгуулан ажиллаж байна. **Хэрэгжилтийн хувь 100** |
| 71 | 3.3.5.3. Ахмад настны хөгжил, оролцоог дэмжих талаар авах арга хэмжээний болон Ахмадын ордон өргөө байгуулах, тэдний үйл ажиллагаанд зарцуулах төсвийн саналыг боловсруулах, Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх, ахмадын өргөөг ахмад настан бүрд нээлттэй байх талаар анхаарч ажиллах. | 139,0 сая төгрөг | 1. Баталсан төсвийн хэмжээ/сая. Төг/ Үйлчилгээнд хамрагдсан ахмад настны тоо | 139,0 сая төгрөг 500 | Аймгийн ахмадын хорооны барилгын засварын санхүүжилтийг аймгийн 2025 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусган шийдвэрлэж засварыг бүрэн хийж дууссан. Ахмадын ордонд өдөр бүр ахмадад чиглэсэн олон төрөлт үйл ажиллагаа тогтмол зохион байгуулагдаж байна. Мөн үйлчилгээнд хамрагддаг ахмад настан 500 байна. **Хэрэгжилтийн хувь 100** |
| 72 | 3.3.5.4. Ахмад настны эрүүл мэнд, идэвхтэй насжилтыг дэмжих төвийг байгуулж, ахмад настны эрэлт, хэрэгцээнд нийцсэн хөгжлийн болон нийгмийн үйлчилгээ үзүүлж, идэвхтэй насжилтыг дэмжих. | - | Үйлчилгээнд хамрагдсан тоо | 300-400 | Ахмадын хороотой хамтран 2 удаагийн нөлөөллийн ажил зохион байгуулан ажилласан. Үйлчилгээнд давхардсан тоогоор 500 хүн хамрагдсан. **Хэрэгжилтийн хувь 100** |
| 73 | 3.3.5.5. Ахмад настны бие бялдар, танин мэдэхүй, сэтгэлзүй, үйл | - | Үйлчилгээнд хамрагдсан ахмадын тоо: | 2 | Ахмад настанд үйлчилгээ үзүүлэх аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулах үнэлгээний хороо 2025 оны 04 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | ажиллагааны чадвар, нийгмийн тулгамдсан асуудлыг тодорхойлох цогц үнэлгээ хийх ажлыг орон нутгийн түвшинд зохион байгуулах. | | | | дугаар сарын 28-ны өдөр 5 гишүүнтэйгээр байгуулагдан ахмадын өдрийн үйлчилгээнд 3 багцад Ахмадын хороо, Дуут Баянбогд, Сахиусан ариун тэнгэр, Зөвлөгөө өгөх үйлчилгээнд Цагдаагийн газрын дэргэдэх ахмадын зөвлөл шалгаран гэрээ байгуулан ахмадуудад үйлчилгээгээ зохион байгуулж байна. Шалгарсан аж ахуй нэгжүүд ахмад настны бие бялдар, танин мэдэхүй, сэтгэлзүй, үйл ажиллагааны чадвар, нийгмийн тулгамдсан асуудлыг тодорхойлох цогц үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах юм .<br>**Хэрэгжилтийн хувь 100** |
| 74 | 3.3.5.6. Ахмад настанд цогц тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтаныг мэргэшүүлэх, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх Орон нутгийн мэргэжлийн хамтарсан багийг байгуулан, үйл ажиллагааг тогтмолжуулж, хяналт тавих | 1,2 | - Орон нутгийн мэргэжлийн хамтарсан багийг байгуулсан эсэх Орон нутгийн мэргэжлийн хамтарсан багийн тайлангийн тоо | Хамтарсан баг байгуулах 2 | Ахмад настанд үйлчилгээ үзүүлэх аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулах үнэлгээний хороо 2025 оны 04 дугаар сарын 28-ны өдөр 5 гишүүнтэйгээр байгуулагдан ахмадын өдрийн үйлчилгээнд 3 багцад Ахмадын хороо, Дуут баянбогд, Сахиусан ариун тэнгэр, Зөвлөгөө өгөх үйлчилгээнд Цагдаагийн газрын дэргэдэх ахмадын зөвлөл шалгаран гэрээ байгуулан ахмадуудад үйлчилгээгээ зохион байгуулж байна. Шалгарсан аж ахуй нэгжүүд ахмад настны бие бялдар, танин мэдэхүй, сэтгэлзүй, үйл ажиллагааны чадвар, нийгмийн тулгамдсан асуудлыг тодорхойлох цогц үнэлгээ хийх ажлыг зохион байгуулна<br>**Хэрэгжилтийн хувь 70** |
| 75 | 3.3.5.7. Ахмад настнаа хүндлэх, ёс заншил, уламжлалаа өвлүүлэх, | 7,8 сая төгрөг | Бүх шатны боловсролын байгууллагад | 30 | Ахмад настнаа хүндлэх, ёс заншил, уламжлалаа өвлүүлэх, мэдлэг, туршлагыг нь залуу үед хүргэх арга хэмжээг зохион |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | мэдлэг, туршлагыг нь залуу үед хүргэх арга хэмжээг зохион байгуулах, ахмад настныг ажиллаж байсан байгууллага болон бүх шатны боловсролын байгууллагад сар бүр сургалт хийлгэх, ахлах ангийн сурагч оюутнуудыг ахмад настанд технологийн, цахим орчин, цахим үйлчилгээний сургалт явуулах зэрэг сайн дурын ажилд татан оролцуулах, урамшуулах | | сургалт хийсэн ахмад настны тоо<br>- Ажиллаж байсан байгууллагадаа сургалт хийсэн ахмад настны тоо | 30 | байгуулахаар ахмадын зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэн зөвлөх үйлчилгээний төсөлд нийт 80 ахмад хүсэлтээ ирүүлснээс 75 иргэнтэй гэрээ байгуулан ажиллаж байна.<br>Хэрэгжилтийн хувь 100 |
| 76 | 3.3.5.8. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35.2.6-д заасан ганц бие орон гэргүй, эсхүл түр байрлуулах газарт байсан иргэн нас барсан, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн нас барсан бол оршуулах үйл ажиллагааг зохион байгуулах, санхүүжүүлэх журмыг батлуулан хэрэгжүүлэх | 20,0 сая төгрөг | - Оршуулах үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ /сая төг/ | 10 сая | Ахмад настны асрамж үйлчилгээний төвд асруулагчдаас болон ганц бие орон гэргүй, хараа хяналтгүй нас барсан иргэн байхгүй.<br>**Хэрэгжилтийн хувь 100** |
| 77 | 3.3.5.9. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн | 12 сая төгрөг | Үйлчилгээнд хамрагдсан иргэний тоо | 3 | Ахмад настны асрамж үйлчилгээний төвд асруулагчдаас болон ганц бие орон гэргүй, хараа хяналтгүй нас барсан иргэн байхгүй.<br>Журмын төсөл боловсруулагдаж байна. |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | 35.2.6-д заасан ганц бие орон гэргүй, эсхүл түр байрлуулах газарт байсан иргэн нас барсан, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн нас барсан бол оршуулах үйл ажиллагааг зохион байгуулах, санхүүжүүлэх журмыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан хэрэгжүүлэх; | | | | **Хэрэгжилтийн хувь 30** |
| 78 | 3.3.5.10. Хөдөлмөрийн тухай хуулийн 145.4-т заасан "Өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 50 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, багууллага нийт ажлын байрныхаа 2 хувиас доошгүй орон тоонд Ахмад настны тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан хүнийг газрын доор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлтэй ажлын барнаас бусад ажлын байранд ажиллуулна." Гэсэн заалтын хэрэгжилтийг хангуулж ажиллуулах, хяналт тавих | - | - 50-иас дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллагад хуулийн дагуу ажиллах ёстой ахмад настны тоо, үүнээс ажиллаж байгаа ахмад настны тоо | 154<br><br>80 | Хяналт шалгалтад 2025 онд 154 аж ахуйн нэгж /үүнээс 50-аас дээш ажилтантай 8 аж ахуйн нэгж/ хамрагдаж 2244 ажилтан ажиллаж байгаагаас ахмад настан 80, хөгжлийн бэрхшээлтэй 64 иргэн ажиллаж байна.<br><br>**Хэрэгжилтийн хувь 100** |
| 79 | 3.3.5.11.Ахмад настны эсрэг гэр бүлийн | | Сургалт, мэдээллийн тоо | 2 | Баянхонгор аймагт 11448 ахмад настан буюу нийт хүн амын 12.9 хувийг эзэлж байна. |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | хүчирхийлэл, тэтгэвэр, тэтгэмж, эдийн болон эдийн бус хөрөнгийн эзэмших, ашиглах эрхийн зөрчил, гэм хорын талаар мэдээлэх дуудлагын тусгай утсыг ажиллуулах, утасны дугаарыг иргэд, олон нийт, ахмад настанд таниулан хүргэх; | | - Сурталчилгаа, нөлөөллийн ажлын тоо | 5 | Аймгийн Ахмадын холбоотой хамтран "Ахмадын өдрийн үйлчилгээнд" хамрагддаг 74 ахмад настанд Гэр бүл хөгжил хамгааллын газраас 4 удаагийн сургалт зохион байгуулсан Гэр бүлд зөвлөгөө өгөх төвөөр ахмад настан нийт 21 үүнээс эрэгтэй 9 эмэгтэй 12 хүнд үйлчилгээ үзүүлсэн. Насаар нь авч үзвэл: 55-59 насны 10, 60-64 насны 6, 65-аас дээш 4 хүн үйлчлүүлсэн байна.<br>Үр дүн: Ахмад настнуудын зөвлөгөө, дэмжлэг авах хүртээмж нэмэгдэж, насны бүлэг бүрт тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, шаардлагатай үйлчилгээ үзүүлэх боломж сайжирсан байна. Гэр бүлд зөвлөгөө өгөх тусгай утас 7044108 тогтмол ажиллаж байна. Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газрын цахим хуудсаар дамжуулан сурталчилж 5602 иргэнд хүрсэн байна.<br>**Хэрэгжилтийн хувь 90** |
| 80 | 3.3.5.12. Ахмад настны асрамжийн үйлчилгээ шинээр үзүүлэх байгууллагад газар эзэмшүүлэх талаар тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөндөө тусган дэмжлэг үзүүлэх; | - | Дэмжлэг үзүүлсэн иргэний тоо | 2 | Ахмад настны асрамжийн үйлчилгээ шинээр үзүүлэх чиглэлээр газар эзэмшүүлэх хүсэлтийг байгууллага, иргэнээс ирүүлээгүй.<br>**Хэрэгжилтийн хувь 100** |
| 81 | 3.3.5.13.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9.2 дахь заалтын хэрэгжилтийг хангах чиглэлээр орон нутгийн аж ахуйн нэгж, | Орон нутгийн төсөв | Тухайн жилийн татвар ногдох орлогоос 1 хүртэл хувийг нийгмийн хариуцлагын хүрээнд зарцуулсан | 17 | Өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 50 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа 2 хувиас доошгүй орон тоонд ахмад настныг газрын доор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлтэйгөөс бусад ажлын байранд |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | байгууллагатай хамтран ажиллах. | | байгууллагын тоо<br>Зарцуулсан хөрөнгийн хэмжээ /сая төг/ | | ажиллуулах хуулийн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.<br>Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9.2 дахь заалтын хэрэгжилтийг ханган аймгийн хэмжээнд 17 байгууллага ахмадын сан байгуулан ажиллаж байна.<br>**Хэрэгжилтийн хувь 100** |
| Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллана. | | | | | |
| 82 | Хөтөлбөрийн 2.1.1.18 дахь заалтын дагуу ахмад настанд Гэр бүлийн цогц төвөөр дамжуулан, тэдний эрэлт хэрэгцээнд нийцсэн хөгжлийн болон нийгмийн үйлчилгээ үзүүлж, идэвхтэй насжилтыг дэмжинэ | | Үйлчлүүлсэн ахмад настны тоо | 50 | Баянхонгор аймагт 11448 ахмад настан буюу нийт хүн амын 12,9 хувийг эзэлж байна. Аймгийн Ахмадын холбоотой хамтран "Ахмадын өдрийн үйлчилгээнд" хамрагддаг нийт 74 ахмад настнуудад үе шаттайгаар сургалт зохион байгуулсан.<br>Гэр бүлд зөвлөгөө өгөх төвөөр ахмад настан нийт 21 үүнээс эрэгтэй 9, эмэгтэй 12 хүнд үйлчилгээ үзүүлсэн. Насаар нь авч үзвэл: 55-59 насны 10, 60-64 насны 6, 65-аас дээш 4 хүн үйлчлүүлсэн байна.<br>Үр дүн: Ахмад настнуудын зөвлөгөө, дэмжлэг авах хүртээмж нэмэгдэж, насны бүлэг бүрт тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, шаардлагатай үйлчилгээ үзүүлэх боломж сайжирсан байна.<br>**Хэрэгжилтийн хувь 90** |
| 83 | Үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.1.7 заалтын дагуу сум, хороо бүрд хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан ажиллуулж, хүүхдийн хөгжих таатай орчныг бүрдүүлж, эрүүл мэнд, боловсрол, хөгжил, | | Нийгмийн ажилтны тоо | 25 | Баянхонгор аймгийн хэмжээнд 20 сум 10 багт 30 хүүхэд гэр бүлийн нийгмийн ажилтныг 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдрөөс томилон ажиллуулж байна. Нийгмийн ажилтнуудыг ажлын байрандаа хөгжих, хүүхэд хамгааллын болон хөгжлийн үйлчилгээг олон нийтэд хүртээмжтэй хүргэх ажлын хүрээнд 2 удаагийн |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | хамгааллын үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэх ажлыг зохион байгуулж ажиллана. | | | | 24-н цагийн чадавхжуулах сургалтаар идэвхжүүлж, 14 хоног тутам кейс хэлэлцүүлэг зохион байгуулж, долоо хоног бүрийн баасан гарагт цахим уулзалтыг тогтмол зохион байгуулж байна<br>Хэрэгжилтийн хувь 100 |
| 84 | Хөтөлбөрийн 2.1.1.8 дахь заалтын дагуу хүүхэд харах үйлчилгээ, өдөр өнжүүлэх үйлчилгээний хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, эмэгтэйчүүдийн болон ганц бие эх, эцгийн хөдөлмөр эрхлэлт, асрахуйн эдийн засгийг дэмжих бодлого баримтлан ажиллана. | - | Хүүхэд харах үйлчилгээ, өдөр өнжүүлэх үйлчилгээ эрхлэгчийн тоо | 8 | Хүүхэд харах үйлчилгээ, өдөр өнжүүлэх үйлчилгээ эрхэлж буй 8 хуулийн этгээд үйл ажиллагаа явуулж байна. Дээрх төвөөр нийт 124 хүүхэд үйлчлүүлсэн.<br>Төвүүдээр төлөвлөгөөт хяналт шалгалтыг хүүхдийн эрхийн улсын байцаагч 6 удаа зохион байгуулан зөвлөмж өгч хэрэгжилтийг хангуулан ажиллалаа.<br>**Хэрэгжилт 90 хувь** |
| 85 | Хөтөлбөрийн 2.1.1.4 заалтын дагуу Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийг хүн амын бүлгүүдийн хөгжлийн болон соёлын төв, иргэний танхимыг түшиглэн байгуулж, бүх аймаг, дүүрэгт төр, хувийн хэвшлийн түншлэлээр ажиллуулж, гэр бүлд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, гэр бүлийн гишүүдийн ёс зүйн хариуцлагыг дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ. | - | Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвөөс сэтгэл зүй тусламж үйлчилгээ авсан гэр бүлийн тоо | 219 | "Гэр бүлд зөвлөгөө өгөх төв"-өөр дамжуулан 416 үйлчлүүлэгчдэд анхан шатны уулзалт зөвлөгөөг өгч ажиллав. Зөвлөгөө авахаар ирсэн иргэдийн 140 буюу 33,6% хүүхэд, 276 буюу 66,4% насанд хүрэгчид байна. Ганцаарчилсан сэтгэл зүйн зөвлөгөөнд нийт 416 хүн, хосын болон гэр бүлийн зөвлөгөөнд 108 хүн хамрагдсан байна.<br>Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх төвөөр үйлчлүүлсэн хүүхдүүдийн 15.7 хувь нь бэлгийн хүчирхийллийн хохирогч болон бэлгийн хүчирхийлэлд өртөх эрсдэлд амьдарч байгаа хүүхдүүд байна. Гэр бүлд зөвлөгөө өгөх төвөөр үйлчлүүлсэн насанд хүрэгчдийн 33,3 хувь гэр бүлийн хүчирхийлэл, 16,6 хувь архины хамаарал, 11,2 хувь үзэл бодлын зөрүүтэй байдал, 13 хувь гэр бүлийн гадуурх харилцаа, ажилгүйдэл болон эдийн засгийн байдал 17,4 хувь байна.<br>Зөвлөгөө өгөх төвөөс Гэр бүлийн боловсрол |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | | | | олгох сургалтад нийт 314 хүн хамрагдсан үүнээс 136 эрэгтэй, 178 эмэгтэй байна.Сургалтаар гэр бүлийн үүрэг хариуцлага, гэр бүлийн хүчирхийлэл, угийн бичиг хөтлөх арга зүй, хүмүүжлийн зэрэг арга, гэр бүл төлөвлөлт, өрхийн төсөв сэдвээр мэдлэг олгосон. Сургалтууд нь хосуудын харилцаа, хандлага, амьдралын ур чадварыг дэмжихэд чиглэгдсэн бөгөөд гэр бүлийн тогтвортой байдлыг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Аймгийн хэмжээнд нийт 5 сум, 3 баг гэр бүлийн зөвлөгөө өгөх төвтэй бөгөөд Богд, Баянговь, Өлзийт, Заг, Гурванбулаг сум болон Баянхонгор сумын 2, 3, 9 дүгээр багт байрлах зөвлөгөөний төвүүд тогтмол үйл ажиллагаа явуулж байна. Дээрх зөвлөгөө өгөх төвүүдээр нийт 89 гэр бүл үйлчилгээ авсан байна. **Хэрэгжилтийн хувь 100** |
| 86 | Хөтөлбөрийн 2.1.1.12 заалтын дагуу эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх орон нутгийн төлөвлөгөөг баталж, төрийн болон төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагын оролцоонд тулгуурлан хэрэгжүүлнэ. | | Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн тоо Өсөлтийн хувь | | Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах конвенцыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2 зорилт 8 ажил арга хэмжээг тусган батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Төлөвлөгөөний хэрэгжилтийн дундаж 70 хувь. Аймгийн хэмжээнд 19947 эмэгтэй хөдөлмөр эрхлэгч байна. **Хэрэгжилтийн хувь 70** |
| 87 | Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт 2.1.1.26-д заасан төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн халамж | 2910.5 сая төгрөг | Халамжаас тэтгэмж авдаг хөгжлийн бэрхшээлтэй иргэний тоо Хөгжлиин бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн тоо | | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн ордон ашиглалтад орж үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Тус төвд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн холбоо, хараагүйчүүдийн холбоо, тэргэнцэртэй иргэдийн холбоо үйл ажиллагаа явуулж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж, |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | үйлчилгээний чанарыг сайжруулж, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд бүх аймаг, дүүрэгт байгуулна | | | | хөнгөлөлтөд 130 иргэнд 62.9 сая төгрөг зарцуулсан. Хөгжлийн бэрхшээлтэй 1263 иргэнд 2910.5 сая төгрөгийн тэтгэврийг цаг тухай бүрд нь олгож байна. **Хэрэгжилтийн хувь 100** |
| 88 | Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт 1.4.1.1-д заасан төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд орон нутгийн нэмэгдлийг төрийн албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингийн 20 хувиар тооцож, улсын төсвөөс, төрийн захиргааны албан хаагчид 80 хувь хүртэл нэмэгдүүлэх эрхийг аймаг, сумын иргэдийн төлөөлөгчдийн хуралд олгох бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | | | | Орон нутгийн нэмэгдлийг төрийн албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингийн 20 хувиар тооцож, улсын төсвөөс, төрийн захиргааны албан хаагчид 80 хувь хүртэл нэмэгдүүлэх олгож байна. **Хэрэгжилтийн хувь 100** |

ТАНИЛЦСАН
ЗАСАГ ДАРГА Э.ЭНХБАТ

ХЯНАСАН
НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА В.НАРАНЧИМЭГ

НЭГТГЭСЭН
ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН А.ӨЛЗИЙСАЙХАН

0324020016
ТУ34247 9007342

Гэр бүл, хөдөлмөр , нийгмийн хамгааллын салбарын хууль тогтоомж, бусад баримт бичигт заасан эрх хэрэгжүүлж , үүрэг гүйцэтгэх гэрээний хавсралт

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР , НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД, БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ (2025 оны жилийн эцэс)

2025 оны 12 дугаар сарын 09 Номгон

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Төсөв /Эх үүсвэр/ | Үр дүнгийн үзүүлэлт | | Хүрсэн түвшин |
|---|---|---|---|---|---|
| | | | Шалгуур үзүүлэлт | Хүрэх түвшин | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 3.1 Гэр бүлийн тухай хууль, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулиар олгогдсон эрх, үүргийн хүрээнд орон нутагт дараах арга хэмжээг авч ажиллана. | | | | | |
| 1 | Гэр бүлийн тухай хуулийг хэрэгжүүлж орон нутагт угийн бичгийн хөтлөлтийн асуудлаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжин туслах багш ажиллуулан, орон нутгийн иргэдийн угийн бичиг хөтлөлтийг зохион байгуулах | - | Сургалтын тоо<br>Хамрагдсан иргэдийн тоо<br>Угийн бичиг хөтлөлтийн хувь | 56<br>5788<br>35.1% | Аймгийн Засаг даргын Тамгын газар, “Ураг удам уламжлалын Хонгор холбоо” төрийн бус байгууллагатай хамтран 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдөр “Өрх бүр – Угийн бичиг” сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулсан. Сургалт, зөвлөгөөнд нийт 250 хүн хамрагдсан бөгөөд угийн бичгийн түүхэн уламжлал, гэр бүлийн хөгжил дэх үүрэг, өнөөгийн байдал болон цаашдын шинэчлэлийн чиг хандлага, угийн бичиг хөтлөөгүйгээс үүдэх хүндрэл бэрхшээл, түүнийг даван туулах арга замуудын талаар мэдлэгтэй болсон. Тайлант оны хугацаанд сум, багийн хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтнуудтай хамтран “Угийн бичиг хөтлөх арга зүй” сэдвээр 71 удаагийн сургалт зохион |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | | | | байгуулж сургалтад нийт 6012 иргэнийг хамруулан угийн бичиг хөтлөхийн ач холбогдлыг сурталчилсан.<br>Аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газартай хамтран **“Шилдэг угийн бичиг”** уралдааныг 2025 оны 11-р сараас 2026 оны 2-р сарын хооронд зохион байгуулахаар ажиллаж байна.<br>Аймгийн хэмжээнд угийн бичиг хөтлөлт 40 хувьтай байна.<br>**Хэрэгжилтийн хувь 100** |
| **3.1.2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар:** | | | | | |
| 1 | Орон нутгийн гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх | 20,155.282 /Хүүхэд хамгааллын зардал/ | тоо/хамрагдсан иргэдийн тоо<br><br>Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэм хэргийн тоо/бууралтын хувь<br><br>Зөрчлийн тоо/ бууралтын хувь | 28/ -9,6<br><br>258/+10 | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг дагаж гарсан 14 журмын хэрэгжилтийг ханган аймгийн 20 сумын Хамтарсан багтай хамтран 25 удаагийн сургалтаар 6251 иргэнд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулийн сургалтыг зохион байгуулсан.<br>Хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх хүрээнд "Хүүхэд, гэр бүлийн өмнө үүрэг хүлээгчид VI зөвлөгөөн", "Хүүхэд, гэр бүлийн өмнө хүн бүр үүрэг хүлээгчид", “Хамтын үнэ цэнэ” гэр бүлийн чуулган зохион байгуулж 3524 иргэнд хүрч ажилласан. Тайлант хугацаанд 4 төрлийн арга хэмжээ зохион байгуулж нийт 9775 хүнд хүрсэн.<br>Үр дүн: Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн 2 гэмт хэрэг бүртгэгдэж өмнөх оны мөн үетэй харицуулахад 5 нэгжээр буюу 71,4 хувь буурсан.<br>147 Зөрчил бүртгэгдэж 69 нэгжээр буюу 32 хувиар буурсан байна. |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | | | | **Хэрэгжилтийн хувь 100** |
| 2 | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр сургалт, мэдээлэл, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулах | 6.482.000 /Гэр бүлийн зардлаас/<br>1.500.000 /Баянхонгор сум /<br>Аймгийн ГХУСАЗСЗ-ийн зардлаас 25.2 сая төгрөг зарцуулсан | Зохион байгуулсан сургалт. нөлөөллийн ажлын тоо | 134 | Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор гэр бүл, хүүхдэд чиглэсэн тэмцээн уралдаан, нөлөөллийн 8 арга хэмжээ зохион байгуулж 1598 иргэдийг хамруулсан Үүнд "Хамтын үнэ цэн гэр бүлийн чуулган, "Аз жаргалтай гэр бүл" марафон гүйлтийн уралдаан, "Эмээ, ээж би" хүндэтгэлийн арга хэмжээ, "Амин холбоо-100" , "Ээж Хүүгийн болзоо" эвент, "Харилцан хүндэтгэе" ,"Хамтаръя-Хэрэгжүүлье-Хайрлая" өдөрлөг, "Хүүхэд, гэр бүлийн өмнө хүн бүр үүрэг хүлээгч" VI зөвлөгөөн зохион байгууллаа.<br>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийг бууруулах дэд зөвлөлийн төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж байна. Төлөвлөгөөнд нийт 10 ажил арга хэмжээ тусган хэрэгжүүлж биелэлт 70 хувьтай байна. Төлөвлөгөөний хүрээнд эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхдүүдэд сэтгэл зүйн оношлогоо баривчлагдсан хүмүүжигч нарын зан үйлд зэргээр нөлөөлөх, “Гэр бүлийн үнэ цэнэ”, “Хүүхдээ сонсъё, ойлгоё” зэрэг сургалт, нөлөөллийн арга хэмжээ, “Үлгэрч өвөө” “Аюулгүй сонголт” хөтөлбөрт арга хэмжээнүүдийг үр дүнтэй зохион байгуулсан.<br>Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 30 хамтарсан баг нь урьдчилан сэргийлэх, хамгаалах, нөхөн сэргээх болон шуурхай тусламжийн үйлчилгээний хүрээнд нийт 151 удаагийн сургалт зохион байгуулж, 15,856 иргэнийг (6002 хүүхэд, 9854 насанд |
| | | | Хамрагдсан иргэдийн тоо | 12472 | |
| | | | Сургалтад хамрагдсан өрхийн эзлэх хувь | 46 | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | | | | хүрэгч) хамруулсан үр дүнтэй байна. Сургалтад хамрагдсан өрхийн эзлэх хувь 58 байна. Үр дүн: Иргэдийн мэдлэг, хандлага сайжирч, үйлчилгээ авах боломж нэмэгдэн, хүчирхийллийг илрүүлэх, мэдээлэх, урьдчилан сэргийлэх ойлголт нэмэгдсэн. **Хэрэгжилтийн хувь 100** |
| 3 | Гэр бүлд зөвлөгөө өгөх төвүүдийн үйл ажиллагааг өргөжүүлж, гэр бүлд сэтгэл зүйн тусламж үйлчилгээ, амьдрах ухааны боловсрол олгох | - | Гэрлэх ёслолын ордны дэргэдэх зөвлөгөө өгөх төвөөс сэтгэл зүй тусламж үйлчилгээ авсан гэр бүлийн тоо | 219 | “Гэр бүлд зөвлөгөө өгөх төв”-өөр дамжуулан 416 үйлчлүүлэгчдэд анхан шатны уулзалт зөвлөгөөг өгч ажиллав. Зөвлөгөө авахаар ирсэн иргэдийн 140 буюу 33,6% хүүхэд, 276 буюу 66,4% насанд хүрэгчид байна. Ганцаарчилсан сэтгэл зүйн зөвлөгөөнд нийт 416 хүн, хосын болон гэр бүлийн зөвлөгөөнд 108 хүн хамрагдсан байна. Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх төвөөр үйлчлүүлсэн хүүхдүүдийн 15.7 хувь нь бэлгийн хүчирхийллийн хохирогч болон бэлгийн хүчирхийлэлд өртөх эрсдэлд амьдарч байгаа хүүхдүүд байна. Гэр бүлд зөвлөгөө өгөх төвөөр үйлчлүүлсэн насанд хүрэгчдийн 33,3 хувь гэр бүлийн хүчирхийлэл, 16,6 хувь архины хамаарал, 11,2 хувь үзэл бодлын зөрүүтэй байдал, 13 хувь гэр бүлийн гадуурх харилцаа, ажилгүйдэл болон эдийн засгийн байдал 17,4 хувь байна. Зөвлөгөө өгөх төвөөс Гэр бүлийн боловсрол олгох сургалтад нийт 314 хүн хамрагдсан үүнээс 136 эрэгтэй, 178 эмэгтэй байна.Сургалтаар гэр бүлийн үүрэг хариуцлага, гэр бүлийн хүчирхийлэл, угийн бичиг хөтлөх арга зүй, хүмүүжлийн зөрөг арга, гэр бүл төлөвлөлт, өрхийн төсөв |
| | | | Сум, багийн зөвлөгөө өгөх төвийн тоо/үйлчлүүлсэн гэр бүлийн тоо | 70 | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | | | | сэдвээр мэдлэг олгосон. Сургалтууд нь хосуудын харилцаа, хандлага, амьдралын ур чадварыг дэмжихэд чиглэгдсэн бөгөөд гэр бүлийн тогтвортой байдлыг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Аймгийн хэмжээнд нийт 5 сум, 3 баг гэр бүлийн зөвлөгөө өгөх төвтэй бөгөөд Богд, Баянговь, Өлзийт, Заг, Гурванбулаг сум болон Баянхонгор сумын 2, 3, 9 дүгээр багт байрлах зөвлөгөөний төвүүд тогтмол үйл ажиллагаа явуулж байна. Дээрх зөвлөгөө өгөх төвүүдээр нийт 89 гэр бүл үйлчилгээ авсан байна. **Хэрэгжилтийн хувь 100** |
| 4 | Орон нутгийн жилийн төсвийн төсөлд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа, нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны урсгал зардал, хамтарсан багийн үйл ажиллагааны зардал, хохирогчид үйлчилгээнд шаардагдах зардлыг төсөвт тусгаж, батлуулах | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | Зарцуулсан төсвийн хэмжээ | 50 сая | Сумд хамтарсан багийн төлөвлөгөөг урьдчилан сэргийлэх, судалгаа мэдээллийн сан бүрдүүлэх, хамгаалал, хариу үйлчилгээ үзүүлэх гэсэн 3 зорилтын хүрээнд гаргаж сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж, хагас, бүтэн жилээр тайлагнаж хэвшсэн. Дараах сумд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа, түүнд шаардагдах зардлыг шийдвэрлэсэн байна. Гурванбулаг сум 1.5 сая, Жаргалант сум 20.3 сая , Бууцагаан сум 10.0 сая, Бөмбөгөр сум 3.1 сая, Баян-Овоо сум 1 сая нийт 35.9 сая төгрөгийн төсөв батлуулан үйл ажиллагаанд зарцуулсан .<br>Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хүүхэд, эмэгтэйчүүдэд хамгааллын үйлчилгээ үзүүлдэг хүчирхийллийн эсрэг "Удвал төв" төрийн бус байгууллагатай 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр үйл ажиллагааны болон санхүүжилтийн гэрээг шинэчлэн байгуулсан. Тус төрийн бус байгууллага нь гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилт 19 арга |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | | | | хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байна. Хүчирхийлллийн эсрэг "Удвал төв" төрийн бус байгууллагын дэргэдэх нэг цэгийн үйлчилгээний төвд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 15 хүүхэд, 5 насанд хүрэгч хамгаалах байранд байрлан аюулгүй байдлын хамгаалалтын үйлчилгээнд 19, эмнэлэгийн тусламж үйлчилгээнд 2, сэтгэл зүйн тусламж үйлчилгээнд 3, боловсролын үйлчилгээнд 2 , нийгмийн халамжийн үйлчилгээнд 9 хүн хамрагдсан байна. Үйлчилгээ авсан хүүхэд, иргэдийг 100 хувь гэр бүлд нь эргэн нэгтгэсэн. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 65 хувийн биелэлттэй. Олгосон санхүүжилт 25,6 сая төгрөг байна<br>**Хэрэгжилтийн хувь 70** |
| **3.1.3. Хүүхдийн эрхийн талаар:** | | | | | |
| 1 | Хүүхдийн эрх, хамгааллын салбар дундын төлөвлөгөө батлан хэрэгжүүлэх | - | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 90% | Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газар, Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Боловсролын газар, Эрүүл мэндийн газрууд хамтран “Хүүхдийн эрх, хамгааллын салбар дундын төлөвлөгөөг 7 чиглэлээр 29 ажил арга хэмжээг тусган боловсруулж батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. хэрэгжилтийн хувь 95,2 хувьтай байна<br>“Салбар дундын үүрэг хүлээгчид, асран хамгаалагчдын хамтын ажиллагааг хангах хүрээнд “Хонгорын хүүхэд” хөтөлбөрийг боловсруулж 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 7/27 дугаар тогтоолоор хөтөлбөрийг батлуулав. “Хонгорын хүүхэд” хөтөлбөрийг танилцуулах сургалтыг 5 удаа зохион байгуулж 8 ерөнхий боловсролын сургуулийн 800 гаруй сурагч, 42 багш хамрагдаж |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | | | | хөтөлбөрийн талаар мэдээлэлтэй болсон. Аймгийн хүүхдийн зөвлөлийн гишүүдтэй хамтран тус хөтөлбөрийг иргэд олон нийтэд таниулан сурталчлах контент хийж байгууллагын пэйж хуудсаар дамжуулан 8500 хүнд мэдээллийг хүргэж ажилласан. Хонгорын хүүхэд хөтөлбөрийг хэрэгжүүлснээр бие бялдрын өсөлт хөгжилтэй хүүхдийн тоо нэмэгдэж, дасгал хөдөлгөөн, шүд, гар угаах дадлыг эзэмшиж халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлнэ. Хүүхдийн үндэсний бичиг, гадаад хэлний боловсролын түвшин сайжирна. Цэцэрлэг, сургуулийн дугуйлан секц хичээллэх анги танхим болон хүүхдийн сурч хөгжих нөхцөл сайжирч, угийн бичиг хөтлөх арга барилд суралцаж, түүх соёлоороо бахархах, үндэсний бичиг, өв соёл, үнэт зүйлээ эрхэмлэн дээдэлдэг зэрэг зан үйлтэй иргэнийг төлөвшүүлнэ. **Хэрэгжилтийн хувь 90** |
| 2 | Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний хүртээмжийг сайжруулж, хүүхдийн авъяас, чадварыг хөгжүүлэх | Хөгжил, оролцооны зардлаас 15,132,900 төгрөг Урьдчилан сэргийлэхээс 7,373,300 төгрөг зарцуулсан. | Хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн орон нутгийн нийт хүүхдэд эзлэх хувь | **35** | Байгууллагын дэргэдэх “Steam hub” хөтөлбөрт 200 хүүхэд, Биеийн тамир спортын газрын дэргэдэх спортын 9 төрлийн секцэд 228 хүүхэд, хүүхдийн Тэмүжин театрын дэргэдэх 4 төрлийн дугуйланд 119 хүүхэд, ерөнхий боловсролын сургуулийн дэргэдэх секц, дугуйланд нийт 9684 хүүхэд тус тус хамрагдаж байна. Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газраас хүүхдийн хөгжлийг дэмжих чиглэлээр зохион байгуулсан урлаг, спортын 10 төрлийн уралдаан тэмцээнд 3538 хүүхэд, Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын экпажийн хөгжлийн хөтөлбөрт 1000 хүүхдийг тус тус |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | | | | хамруулж нийт 14769 хүүхдийн хөгжлийг дэмжин, үйлчилгээний хүртээмжийг сайжруулж, авьяас чадварыг нь нээн хөгжүүлсэн. Энэ нь орон нутгийн нийт хүүхдийн 44,7 хувийг эзэлж байна. Хэрэгжилтиин хувь 100 |
| 3 | "Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих салбар зөвлөл"-ийн үйл ажиллагаанд шаардагдах төсвийг тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлуулах | Орон нутгийн төсөв 3.0 сая | Баталсан төсвийн хэмжээ | **3.0 сая** | Аймаг хөгжүүлэх 2025 оны жилиин хөгжлийн төлөвлөгөөнд 3 сая төгрөгийн тусган батлуулж дараах үйл ажиллагааг зохион байгуулсан байна. Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих орон тооны бус зөвлөлийг аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/704 дугаар захирамжаар байгуулан салбар дундын уялдааг ханган ажиллаж байна. Эрүүл мэндийн газрын дарга 2025 онд нарийн бичгээр ажиллаж байна. Бага насны хүүхдийн хөгжлийн цогц бодлогыг хэрэгжүүлэх салбар дундын 2025 оны төлөвлөгөөнд 17 ажил арга хэмжээг тусган хэрэгжүүлж байна. Үйл ажиллагаанд зарцуулах төсвийг аймгийн 2025 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусган батлуулсан. "Сургуулийн өмнөх боловсролын өнөөгийн чиг хандлага" сэдэвт сургалт, туршлага солилцох ажлыг зохион байгуулж, 32 цэцэрлэгийн 77 багш хамруулан сургагч багшаар бэлтгэх үйл ажиллагаанд 2025 онд төлөвлөгдсөн төсвийг зарцуулсан. Бага насны хүүхдийн хөгжил, төлөвшил, эрүүл мэндийг дэмжих чиглэлээр 9 төрлийн сургалт арга хэмжээг зохион байгуулж 4240 хүүхэд, 2526 насанд хүрэгч хамрагдсан Төлөвлөгөөнии биелэлт 100 хувьтай байна **Хэрэгжилтийн хувь 100** |
| 4 | Аж ахуйн нэгжийн орлогын | - | Байгууллагын тоо | 0 | Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | албан татварын тухай хуулийн 22.9 дүгээр заалтыг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах | | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ | 0 | тухай хуулийн 22.9 дүгээр заалтыг хэрэгжүүлэх хүрээнд 1 арга хэмжээг хэрэгжүүлж 1 аж ахуй нэгж хөнгөлөлт эдэлж байна. Өвгөнжаргалант хүүхдийн зуслангийн спорт талбайн тохижилтын ажлын гүйцэтгэгчээр "Базардарь" ХХК тендерт шалгарч 123.4 сая төгрөгөөр ажил гүйцэтгэж хүлээлгэн өгсөн. **Хэрэгжилтийн хувь 100** |
| 5 | Аймгийн Хүүхдийн зөвлөл, хүүхдийн оролцооны байгууллагуудыг байр танхимаар хангах, шийдвэр гаргах түвшинд хүүхдийн оролцоог хангах ажиллах | - | Байр танхимаар оролцооны байгууллагын тоо | 2 | Хүүхдийн оролцооны 3 байгууллагыг Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газрын байранд өрөө танхимаар ханган ажиллаа. Аймгийн Хүүхдийн зөвлөл, 20 сумын 32 сургуулийн хүүхдийн зөвлөл болон бусад 10 оролцооны байгууллагын гишүүдийг чадавхжуулах сургалтыг танхимаар 2, цахимаар 1 удаа зохион байгуулж арга зүйгээр ханган ажилласан. Тус хүүхдийн өөрийн удирдлагын байгууллагуудтай 18 арга хэмжээг зохион байгуулж танхимаар 4895, цахимаар 12,370 хүүхэд, залуучуудад хүрч ажилласан байна. Хүүхдийн оролцооны өөрийн удирдлагын байгууллагын төлөөлөгч хүүхдүүдийг Монголын хүүхдийн үндэсний чуулган, майхант цугларалт, Өсверийн парламент хөтөлбөр, аймгийн хүүхдийн нэгдсэн чуулганы үйл ажиллагаанууддад оролцуулснаар шийдвэр гаргах түвшинд хүүхдийн оролцоог хангаж ажилласан болно. **Хэрэгжилтийн хувь 100** |
| | "Олон нийтийн байцаагч"-ийг ажиллуулж, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлж, хүүхэд хамгааллын үйлчилгээ | Орон нутгийн төсвөөс 32 сая төгрөг | Олон нийтийн байцаагчийн тоо | 20 | Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зохицуулах зөвлөлөөс 38 "Олон нийтийн цагдаа"-ийн орон тоог баталсан аймгийн хэмжээнд 22 олон нийтийн цагдаа ажиллаж байна. Аймгийн хэмжээнд гэмт |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | үзүүлнэ | | | | хэрэг, зөрчил гарсан газар, ул мөрийг хамгаалах, оршин суугаа газрын хаягийг тогтоох, хэв журам сахих, нийтийн хэв журам хамгаалах талаар хууль сахиулах байгууллага болон бусад хуулийн этгээдээс зохион байгуулж байгаа ажилд оролцох зэрэг хууль тогтоомжоор заасан чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. **Хэрэгжилтийн хувь 100** |
| **3.1.4. Хүүхэд хамгааллын талаар:** | | | | | |
| 1 | Хүүхэд хамгааллын бодлогыг сурталчлан таниулж, салбар бүрд мөрдүүлэх | - | Хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлж буй байгууллагын тоо | 20 | Хүүхэд хамгааллын бодлогыг сурталчлах ажлын хүрээнд Хүүхэд хамгааллын тухай хуулийн 52.7 дахь заалтын дагуу байгууллагын нийт цалингийн сангийн нэгээс доошгүй хувьтай тэнцэх хэмжээний санг бүрдүүлж “Хүүхэд хамгааллын бодлого”-ыг хэрэгжүүлэхэд зарцуулах талаарх сургалт мэдээллийг 105 байгууллагын 2400 албан хаагчдад зохион байгуулсан. Аймгийн хэмжээнд хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлж буй 175 төрийн байгууллага, 23 аж ахуйн нэгж, байгууллага байна. **Хэрэгжилтийн хувь 90** |
| 2 | Орон нутгийн хэмжээнд 2020-2024 онд хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан хүүхэд, үрчлэгдсэн хүүхэд, бүтэн өнчин хүүхдийн нөхцөл байдалд үнэлгээ хийж, мэдээллийн санд бүртгэх, шаардлагатай хүүхэд хамгааллын үйлчилгээг бүрэн хүргэх | Төсөв- 25,000,000 /Хамгааллын зардал/ | Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн тоо | 250 | Орон нутгийн хэмжээнд 2020-2024 онд хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан хүүхэд-1200, үрчлэгдсэн хүүхэд-136, бүтэн өнчин 76 хүүхдийн нөхцөл байдалд үнэлгээ хийж 64-н төрийн болон төрийн бус аж ахуй нэгжүүдэд хуваарилан, мэдээллийн санд бүртгэн ажилласан. Тайлант онд Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн судалгаа мэдээллийг шинэчлэн гаргахад эрсдэлт нөхцөлд нийт 1877 байгаа нь нийт хүүхдийн 5.6 хувийг эзэлж байна. Эдгээр хүүхдүүдээс сургуулийн дэргэдэх |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | | | | хөгжлийн секц, дугуйланд 84, байгууллагаас зохион байгуулсан тэмцээн уралдаанд 57, Олон улсын Найрамдал цогцолборт 27, хүүхдийн театр, спортын төв ордны дэргэдэх секц, дугуйланд 56 хүүхэд. нийт 224 хүүхэд хамрагдаж байна. Энэ нь эрсдэлт нөхцөлд байгаа нийт хүүхдийн 11.9 хувийг эзэлж байна.<br>Эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа болон гэмт хэргийн хохирогч, холбогдогч 945 хүүхдийг хамгааллын үйлчилгээнд хамруулсан нь нийт эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн 50,3 хувийг эзэлж байна.<br>**Хэрэгжилтийн хувь 90** |
| 3 | Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог шинэчлэн байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, шаардлагатай зардлыг орон нутгийн төсвөөс хуваарилаж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч хүүхэд бүрд үйлчилгээг бүрэн хүргэх | Төсөв-17.300.000 /Хамгааллын зардал/ | Хууль зүйн хорооны үйлчилгээ авсан хүүхдийн үйлчилгээ авах шаардлагатай нийт хүүхдэд эзлэх хувь | 97<br>5% | Аймгийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 09-ны А/210 дугаар захирамжийн дагуу хүүхдийн эрхийн хууль зүйн хороог шинэчлэн байгуулж төлөвлөгөөг батлуулан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч сэжигтэн-23, хохирогч-55, гэрч-10 зөрчлийн хохирогч-32, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан-4 нийт 94 хүүхэд үйлчилгээ үзүүлж ажилласан. Хууль зүйн хорооны үйлчилгээ авсан хүүхдийн үйлчилгээ авах шаардлагатай нийт хүүхдэд эзлэх хувь 7,8 байна.<br>**Хэрэгжилтийн хувь 90** |
| 4 | Хурдан морины уралдаан болон морины сунгаа, уралдааны бэлтгэлийн үед уралдаанч хүүхдийн эрх, амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангаж хяналт тавих | Төсөв-11,200.000 /Хамгааллын зардал/ | Хяналт тавьж ажилласан уралдааны тоо<br><br>Бүртгэгдсэн уралдаанч хүүхдийн тоо | 25<br><br>1320 | Аймгийн хэмжээнд 2025 оны 5 сарын 01-ний өдрөөс эхлэн нийт бүсийн хурдан морины 5 уралдаан Галуут, Гурванбулаг, Баян-Өндөр, Шинэжинст, Баянхонгор сумдад зохион байгуулагдсан. Уралдааныг зохион байгуулж байгаа сумдын ЗДТГ, уяачдын холбоодод зөвлөмж хүргэж, сум тус бүрд уралдаанч хүүхдийн аюулгүй байдал, эрхийг хангахад |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| 5 | | | Хүүхдийн бэртэл гэмтлийн хувь | 5% | мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хяналт тавин ажиллаа. Ардын хувьсгалын 104 жилийн ой, Хонгорын шигшмэл хурд, сумдын баяр наадамд уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг хангаж ажилласан. Тайлант онд нийт 27 зөвшөөрөлтэй уралдаанд 1011 уралдаанч хүүхэд бүртгэгдсэнээс 1 хүүхэд хөнгөн бэртсэн. **Хэрэгжилтийн хувь 100** |
| 5 | Гамшиг онцгой байдлын үед, ган зуд, үер усны улмаас хохирсон өрхийн судалгаа, мэдээллийг нэгтгэн гаргаж, салбар дундын хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөгөө гарагж хэрэгжүүлэх | - | Үйлчилгээ авсан өрхийн тоо, хүүхдийн тоо | 128 | Болзошгүй эрсдэл, байгалийн гамшиг, онцгой байдлын үед, ган зуд, үер усны улмаас хохирсон өрхийн судалгаа, мэдээллийг нэгтгэн гаргах, тэдэнд хамгааллын үйлчилгээ үзүүлэх салбар дундын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж байна. төлөвлөгөөний хэрэгжилт 91 хувь. Болзошгүй эрсдэл, байгалийн гамшиг, онцгой байдлын үед, ган зуд, үер усны улмаас хохирсон өрхийн судалгаа, мэдээллийг нэгтгэн гаргах, тэдэнд хамгааллын үйлчилгээ үзүүлэх салбар дундын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж байна. Гамшиг, гамшигийн онцгой нөхцөл байдалд өртсөн хүүхэд, гэр бүлийн судалгааг 2020-2025 онуудад гаргасан. Үүнд: 2020 онд 36, 2021 онд 64, 2022 онд 21, 2023 онд 5, 2024 онд 3, 2025 онд 2 хүүхэд, нийт 131 хүүхэд гамшгийн эрсдэлт нөхцөлд өртсөнөөс нас барсан хүүхдийн тоо 11. Гамшгийн эрсдэлд өртсөн хүүхэд бүрд хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх кэйс нээн ажилласан. Онцгой байдлын газартай хамтран зорилтот 25 гэр бүлд гамшгаас урьдчилан сэргийлэх, |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | | | | галын аюулгүй байдал, ахуйн осол гэмтэл, анхан шатны тусламж үзүүлэх чиглэлийн цогц сургалтыг зохион байгуулсан. **Хэрэгжилтийн хувь 90** |
| 6 | Хүүхдийн тоглоомын талбай, орон сууцны гэрэлтүүлэг, цахилгаан сүлжээний аюулгүй байдал, замын далан, ухсан нүх, суваг, шуудуу, траншей, худаг орчимд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, шаардлагатай засвар үйлчилгээг хийх, анхааруулах тэмдэг байршуулж, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлнэ; | - | Осол гэмтлийн буурсан хувь | - | Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар, Аймгийн Цагдаагийн газартай хамтран 45 тоглоомын төв, 3 PC тоглоомын төв, 5 дугуй засварын газар, 3 биллиардын төвд хяналт шалгалтыг зохион байгуулсан. Хяналт шалгалтад хамрагдсан нийт 45 тоглоомын төвд тоглоомын аюулгүй байдлыг хангах, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх чиглэлээр зөвлөмжийг өгсөн. Баянхонгор аймгийн 30 хамтарсан баг болон хүүхдэд үйлчилгээ үзүүлдэг төрийн байгууллагуудад орон нутаг, байгууллагын ойр орчин, гудамжны гэрэлтүүлэг, цахилгааны аюулгүй байдал, ухсан нүх, траншей, худаг, замын хөдөлгөөний аюулгүй байдалд эрсдэлийн үнэлгээ, хяналт шалгалт хийх, зөрчлийг арилгаж хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх чиглэлээр ажлын чиглэл өгч ажилласан. 15 удаагийн хяналт шалгалтыг 56 аж ахуйн нэгжид зохион байгуулсан. Осол гэмтэл гараагүй байна **Хэрэгжилтийн хувь 90** |
| 7 | Хүүхдийн хөгжлийн сургалтын төв, өдөр өнжүүлэх төв, хүүхэд харах үйлчилгээ, сүм хийд, худалдаа үйлчилгээний газар, амралт сувилал, аялал жуулчлалын газруудад хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан | - | Хүүхдийн эрхийн зөрчил буурсан хувь | 5% | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 420 дугаар тогтоолоор батлагдсан хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсан 8, ажил арга хэмжээний биелэлт 89 хувь. Төлөвлөгөөт хяналт шалгалтын тоо нийт 6 удаа зохион байгуулж, 243 байгууллага, аж ахуйн нэгжид хүрч ажилласан. Хяналт шалгалтаар нийт илэрсэн 7 зөрчлийг арилгуулах зөвлөмжийг хүргэж ажилласан. |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгуулах | | | | Хүүхдийн эрхийн зөрчил 8% буурсан байна **Хэрэгжилтийн хувь 100** |
| **3.2 Хөдөлмөрийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4, 15.6, 33 дугаар зүйлийн 33.1, 36 дугаар зүйлийн 36.1.3, 159 дүгээр зүйлийн 159.2 заалтын хэрэгжилтийг хангаж дараах арга хэмжээг авч ажиллана** | | | | | |
| 1 | Зохистой хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг бий болгохтой холбоотой Хөдөлмөрийн хуулийн зохицуулалтыг орон нутгийн хэмжээнд ажил олгогч, ажилтанд сурталчлан таниулах, хуулийн хэрэгжилтийг хангах; | - | Хамрагдсан салбар, аж ахуй нэгж байгууллагын тоо | 50 | Зохистой хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор нийгмийн түншлэгч талуудтай хамтран Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох эрх зүйн зохицуулалтын талаар аймгийн хэмжээнд дараах салбаруудыг хамруулан сургалт, сурталчилгааны 6 салбарын 67 аж ахуй нэгж байгууллага, 256 хувиараа хөдөлмөр эрхлэгчийг хамруулсан. Үүнд: Үйлдвэрлэл 14, Хөдөө аж ахуй 15, Барилга 11, Худалдаа, үйлчилгээ 5, Боловсрол 13, Эрүүл мэнд 9 Хувиараа хөдөлмөр эрхлэгч 256 байна<br>Сургалтаар хөдөлмөрийн гэрээ, дотоод журам, цалин хөлс, ажил олгогч, ажилтны эрх үүргийн талаар мэдээлэл өгч, хууль зөрчихөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж өгсөн нь ажил олгогч, ажилтан хоорондын харилцааг сайжруулахад бодитой хувь нэмэр оруулаа.<br>**Хэрэгжилтийн хувь 100** |
| 2 | Орон нутаг дахь бичил, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, ажил олгогчийн дэмжих хөдөлмөр эрхлэлтийн арга хэмжээг дэмжих (хөдөлмөрийн харилцааны хөтөлбөр)-ийн хэрэгжилтийг зохион | 7 сая | Хамрагдсан аж ахуйн нэгж байгууллагын тоо | 5 | Хөдөлмөрийн харилцааны хөтөлбөрт "Далай ээж Баянхонгор" ХХК, "Сод баян" ХХК, Баянхонгор тээвэрчин ХХК, Кристаллс ХХК, Баялаг дулаан ХХК, Ган мөнхжин ХХК, Баянжаргант хүнс ХХК-уудыг сонгон, хөдөлмөрийн харилцааны чиглэлээр мэргэшсэн зөвлөхүүдийг ажиллуулж, хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | байгуулахад дэмжлэг үзүүлэх; | | | | Зөвлөхүүд байгууллагын хөдөлмөрийн гэрээ, дотоод журам, ажил олгогч, ажилтны эрх үүрэг, эрх зүйн баримт бичгийн боловсруулалт зэрэгт дэмжлэг үзүүлж, хууль эрх зүйн хэрэгжилтийг сайжруулахад чиглэсэн арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа<br>**Хэрэгжилтийн хувь 100** |
| 3 | Аймаг, нийслэлийн хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хороо, хөдөлмөрийн арбитр, хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллах; | - | Хөдөлмөрийн сонирхлын болон эрхийн маргааны тоо | 10<br>0 | Хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хороонд ирсэн 11 өргөдлийг хүлээн авч, 12 удаа хуралдаж 100 хувь шийдвэрлэн ажилласан. Хөдөлмөрийн маргаанаас урьдчилан сэргийлэх зорилгоор Аймгийн үйлдвэрчний эвлэлийн холбоотой хамтран 13 удаагийн сургалтаар 20 аж ахуйн нэгжид зөвлөгөө өгч, хөдөлмөрийн эрх зүйн мэдлэг олгох мэдээлэл, арга зүйгээр ханган ажилласан.<br>**Хэрэгжилтийн хувь 100** |
| 4 | Аймаг, сумын хамтын хэлэлцээрийг байгуулах, хэлэлцээрийн биелэлтэд хяналт тавих, хэрэгжилтийг зохион байгуулахад санаачилгатай ажиллах; | - | Хөдөлмөрийн тухай хууль тогтоомжид нийцүүлж бүртгэсэн хэлэлцээрийн тоо | 5 | Аймгийн Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хороо 2025-2027 онд хэрэгжүүлэх хамтын хэлэлцээрийг хөдөлмөрийн харилцаа, хүн амын чанартай, хүртээмжтэй хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрлөх эрх, аюулгүй байдал, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зэрэгт баримтлах чиглэлийг зохицуулан, хэрэгжүүлэхээр 7 бүлэг 50 заалтыг тусгаж байгуулан, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.<br>Хамтын гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт тавьж 21 байгууллага, 6 суманд үзлэг, шалгалт хийж, 46 хамтын гэрээ, 7 хамтын хэлэлцээр нийт 60 гэрээ, хэлэлцээрийг |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | | | | бүртгэж, хөдөлмөрийн харилцааны ил тод байдал, түншлэлийг бэхжүүлэхэд анхаарч ажиллаж байна.<br>**Хэрэгжилтийн хувь 100** |
| | | | 3.2.2Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар | | |
| 1 | 2025-2028 онд орон нутгийн хөгжилд ач холбогдолтой, орон нутгийн онцлогтой үйлдвэр, үйлчилгээний салбар, чиглэлийг тодорхойлж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ажил олгогчийн судалгааг гаргах, шаардлагатай дэмжлэгийн саналыг боловсруулах; | | Бодлогын баримт бичгийн тоо<br>Судалгаа, мэдээллийн тоо | 1<br>1 | Аймгийн тэргүүлэх салбарууд болох уул уурхай, иргэний барилга, авто зам, хөдөө аж ахуй, хоол үйлдвэрлэл, орон байраар үйлчлэх үйлчилгээний чиглэлээр нийт 1194 ажлын байрны захиалга ирүүлсэн нь нийт ажлын байрны захиалгын 62.1 хувийг бүрдүүлж байна.<br>2025–2028 оны төлөвлөлтийн хүрээнд дээрх тэргүүлэх салбаруудад үүсээд буй ажиллах хүчний хомсдолыг бууруулах, хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах зорилгоор хөдөлмөрийн зах зээлийн нийлүүлэлт эрэлтийн уялдаа, сургалтын байгууллагуудтай хамтын ажиллагааг сайжруулах, ажлын байрны мэдээллийн ил тод байдал, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын ажиллах хүчний тогтвортой байдлыг дэмжих, бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулах зэрэг үе шаттайгаар зохион байгуулж, орон нутгийн хөдөлмөрийн нөөцийг нэмэгдүүлэх санал боловсруулж холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.<br>**Хэрэгжилтийн хувь 100** |
| 2 | 3.2.2.2.Орон нутгийн ажилгүйдэл, хөдөлмөр эрхлэлт, ядуурлын статистик мэдээлэл, бүртгэлтэй ажилгүй, ажлын | | Судалгаа мэдээллийн тоо | 11 | Судалгаа мэдээллийн тоо 11 байна. Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийг сар бүр өссөн дүнгээр боловсруулан, ажил хайгч иргэн, бүртгэлтэй ажилгүй иргэн, шинээр бий болсон ажлын байр, ажлын байрны |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | байрны захиалга зэрэг захиргааны мэдээний чанарыг сайжруулах, тогтмол шинэчлэх; | | | | захиалга, ажилд зуучлал зэрэг үндсэн үзүүлэлтүүдийн хүрээнд нэгтгэн гаргаж байна. Уг мэдээллийг аймгийн статистикийн албан ёсны тайлан, мэдээнд тогтмол хүргүүлж байгаа нь хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн үнэн бодит байдал, чанарыг сайжруулах, мэдээллийг цаг тухайд нь шинэчилж, бодлогын шийдвэр гаргахад нотолгоонд суурилсан мэдээллээр хангах чухал ач холбогдолтой ажил болж байна.<br>Бүртгэлтэй ажилгүй иргэд 2025 оны 11 дүгээр сарын байдлаар 141 иргэн бүртгэгдсэн ба өмнөх онтой харьцуулахад 626 иргэнээр бага байна.<br>2025 онд ажил олгогчдоос нийт 1194 ажлын байрны захиалга ирүүлсэн бөгөөд эдийн засгийн салбарын ангиллаар авч үзвэл хамгийн их эрэлттэй салбарууд болох хөдөө аж ахуй, уул уурхай, барилгын салбар нь нийт ажлын байрны захиалгын 62.1 хувийг эзэлж байна.<br>**Хэрэгжилтийн хувь 100** |
| 3 | 3.2.2.3.Орон нутгийн хүн амын бүлгүүд(эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, оюутан залуучууд зэрэг)-ийн хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл, ядуурлын нөхцөл байдлын судалгаа хийх, бүртгэл мэдээллийн сан үүсгэх, онцлог, хэрэгцээнд нь нийцсэн тусгайлсан арга хэмжээг | | 1. Аймгийн ажилгүйдэл, ядуурал, хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтийн тооны өсөлт, бууралтын хувь<br>2. Аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажилгаагааны хэрэгжилтийн тооны өсөлтийн хувь | Хүн амын бүлэг тус бүрээрх судалгаа хийгдэж, бүртгэл мэдээллийн сан үүсч, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. | Сүүлийн 4 жилд хөдөлмөр эрхлээгүй, хөдөлмөрийн насны хүн 1-5 хувь өсч ажиллах хүчний оролцооны түвшин 71,0 хувьтай байгаа нь 4 жилийн өмнөх үеийн өсөлтийн дундажтай харьцуулахад тогтвортой байна.<br>Өнгөрсөн оны эцсийн байдлаар аймгийн хэмжээнд хөдөлмөрийн дутуу ашиглалт 6.1 хувьтай, Ажилгүйдлийн үргэлжлэх хугацаа 4-5 жил, ажилгүйчүүдийн зах зээлд 15-19 нас, 30-34 насны ажилгүйчүүдийн эзлэх хувь |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | авч хэрэгжүүлэх; | | 3. Аймгийн ажилгүйдэл, ядуурлыг бууруулах үйл ажиллагаанд төлөвлөсөн хөрөнгө, гүйцэтгэлийн өсөлтийн хувь | | өндөр байна.<br><br>Хөдөлмөрийн эрхлэлтийн түвшин 2021 оноос 2024 он хүртэл 4,8 пунктийн өсөлттэй байгаа ч ажлын байрны тогтвортой өсөлтийг бий болгож чадахгүй, албан бус секторт хөдөлмөрлөх иргэдийн тоо нэмэгдэж байна.<br><br>Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэгт 55 ахмадад 300.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон.<br><br>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэмжлэгт 26 иргэнийг 200.0 сая төгрөгөөр дэмжиж үр дүнд 35 ажлын байр бий болсон.<br><br>25 ба түүнээс дээш насны, иргэн, аж ахуйн нэгж, бичил бизнес, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх хүсэлтэй 45 иргэнд нийт 450.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлснээр 203 ажлын байр шинээр бий боллоо.<br><br>Эдгээр арга хэмжээ нь зорилтот бүлгийн иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, өөрийн хөдөлмөрөөр амьжиргаагаа дээшлүүлэх нөхцөл бүрдүүлэхэд чухал хувь нэмэр оруулсан.<br><br>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээнд 2024 онд **1276** иргэн ажлын байраар хангагдаж, 2,835,480,880 төгрөгийг, 2025 онд нийт 895 иргэн хамрагдаж 1,668.9 сая төгрөгийг тус тус зарцуулсан ба өмнөх онтой харьцуулахад хамрагдсан хүн 29,9 хувиар, зарцуулсан мөнгөн дүн 41,1 хувиар тус тус бага байна.<br><br>**Хэрэгжилтийн хувь 100** |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| 4 | 3.2.2.4 Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа авдаг хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай иргэний хөдөлмөр эрхлэх, аж ахуй эрхлэх хүсэл сонирхол, санал санаачилгыг бий болгох, дэмжих замаар халамжаас хөдөлмөрт шилжих бодлогын хэрэгжилтийг хангуулах; | 93,0 сая төгрөг | Нийгмийн халамжийн авагчаас хөдөлмөр эрхлэгч болсон иргэний тоо<br>Холбогдох арга хэмжээний тоо<br>Төлөвлөсөн зарцуулсан хөрөнгийн хэмжээ | 40<br>2<br>90 сая | Нийгмийн халамжийн авагчаас хөдөлмөр эрхлэгч 43 иргэн болсон байна Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа авдаг хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай иргэний хөдөлмөр эрхлэх, аж ахуй эрхлэх хүсэл сонирхол, санал санаачилгыг бий болгох 2 арга арга хэмжээг зохион байгуулан ажиллалаа. Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа авдаг хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай 37 иргэнийг байнгын, түр ажлын байранд 36 иргэнийг зуучилсан.<br>**Хэрэгжилтийн хувь 100** |
| 5 | 3.2.2.5 Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төв (Job center)-ийг орон нутагт нээн ажиллуулах, дэмжлэг үзүүлэх; | | 1. Ажилд зуучлуулсан иргэний тооны өсөлт<br>2. Холбогдох арга хэмжээний тоо | 2<br>2 | 2026 оны аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөнд төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд Job Center буюу хөдөлмөрийн биржийг шинээр байгуулах саналыг тусган ажиллаж, энэхүү ажлын хүрээнд 100 мкв талбай бүхий ажлын байрны засвар, тохижилтын бэлтгэл ажлыг үе шаттайгаар ханган хэрэгжүүлж байна.<br>**Хэрэгжилтийн хувь 100** |
| 6 | 3.2.2.6.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүгийн дэмжлэг авсан ААНБ, ТББ, хувь хүн санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэх, ажлын байр бий болгосон эсэхэд хяналт тавих; | | Хяналт шалгалтын тоо<br>Судалгаа мэдээллийн тоо<br>Холбогдох арга хэмжээний тоо | 2<br>1<br>2 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас дэмжлэг авсан байгууллагуудад шинэ ажлын байр бий болгосон эсэхэд 3 удаа хяналт шалгалтыг зохион байгуулан анхаарах асуудлын хүрээнд 2 зөвлөмж мэдээллийг боловсруулан аж ахуй нэгж байгууллагуудад хүргүүллээ зохион байгууллаа.<br>Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа Сургалт, үнэлгээ, судалгааны институтын хамтарсан баг "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан"-гаас санхүүгийн |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | | | | дэмжлэг авсан аж ахуйн нэгж, байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан эсэх, ажлын байр шинээр бий болгосон байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажиллав. Энэхүү хүрээнд нийт 77 иргэний ажлын байранд очиж үнэлгээ өгч, хамтран ажилласан.<br>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагаанд 2 удаа дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж холбогдох мэргэжилтнүүдэд зөвлөмж өгч ажиллаж байна.<br>**Хэрэгжилтийн хувь 100** |
| 7 | 3.2.2.7.Техник технологийн хөгжил дэвшилд тулгуурласан бүтээмж өндөртэй, инноваци шингэсэн шинэлэг санал санаачилгыг дэмжих, холбогдох төрийн болон хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллахад нь дэмжлэг үзүүлэх; | 30,0 сая төгрөг | Холбогдох арга хэмжээний тоо<br>Арга хэмжээнд хамрагдсан хүний тоо<br>Төлөвлөсөн зарцуулсан хөрөнгийн хэмжээ<br>Шинээр бүртгүүлсэн патент/шинэ бүтээл, ашигтай загвар/-ын тоо | 2<br>2<br>30.0 сая | Техник технологийн хөгжил дэвшилд тулгуурласан бүтээмж өндөртэй, инноваци шингэсэн шинэлэг санал санаачилгыг дэмжих хүрээнд 52 иргэнийг хамруулан 2 удаагийн арга хэмжээ зохион байгуулан ажиллаа.<br>Инноваци шингэсэн шинэ санаа, гарааны бизнесийг дэмжих зорилгоор "Startup-2025" арга хэмжээг Startup Mongolia-тай хамтран амжилттай зохион байгуулж, нийт 13 багийн 52 залуучууд сургалт, ур чадварын хөтөлбөрүүдэд хамрагдав. Үүний үр дүнд 5 баг хурдасгуур хөтөлбөрт, 2 баг тус бүр 15 сая төгрөгийн санхүүжилт авч шалгарлаа.<br>Мөн Хангайн бүсийн шилдэг стартап шалгаруулах тэмцээнд Архангай, Өвөрхангай, Баянхонгорын 12 баг өрсөлдөхөд Баянхонгор аймгийн 2 баг 1, 3-р байранд шалгарч, нийт 35 сая төгрөгийн |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | | | | санхүүжилт авсан байна.<br>Шинээр бүртгүүлсэн патент/шинэ бүтээл, ашигтай загвар/ 4 бүртгэн авч үйл ажиллагааг эрчимжүүлэн ажиллаж байна.<br>**Хэрэгжилтийн хувь 100** |
| 8 | 3.2.2.8.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжилт авсан ААНБ, иргэдийн бараа бүтээгдэхүүнд борлуулалтын дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг шинэ төвшинд гаргаж, арга барилыг сайжруулж шинэчлэх, томоохон ААНБ-тай гэрээ байгуулж, борлуулалт хийх, хамтран ажиллах гарцыг бий болгох; | 54.988.000 төгрөг | Борлуулалтын дэмжлэгт хамрагдсан хүний тоо<br>Төлөвлөсөн, зарцуулсан хөрөнгийн хэмжээ | 50<br>55.0 сая ₮ | Борлуулалтын дэмжлэгт 114 иргэнийг хамруулсан.<br>"Баянхонгорт үйлдвэрлэв" нэрийн дэлгүүрийг тогтмол үйл ажиллагаатайгаар ажиллуулж, 2025 онд 4.8 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэв.<br>Мөн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжилт авсан ААНБ, иргэдийн бараа бүтээгдэхүүнийг олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор "Мөнхийн үсэг" компанитай хамтран цахим болон хэвлэмэл 600 ширхэг сэтгүүл бэлтгэн гаргав.<br>Үүнээс гадна "Намрын ногоон өдрүүд" үзэсгэлэн худалдаанд 74 иргэнийг оролцуулж, бараа бүтээгдэхүүнээ борлуулах боломжийг бүрдүүлэн 5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.<br>**Хэрэгжилтийн хувь 100** |
| 9 | 3.2.2.9. Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, дүүргийн зөвлөлийн чиг үүргээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллах; | ХЭДС | Холбогдох арга хэмжээний тоо | 5 | "2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөл хуралдаж, орон нутагт хэрэгжүүлэх хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны бодлого, чиглэлийг 01 дүгээр тогтоолоор баталсан. Тогтоолыг 100 хувь хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>**Хэрэгжилтийн хувь 100** |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
